

# СУУРЬШЛЫН БҮС ДЭХ ТЭЖЭЭВЭР АМЬТАНТАЙ ХОЛБООТОЙ СТАНДАРТЫН СУУРЬ СУДАЛГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
ТББ	Төрийн бус байгууллага
БГД	Баянгол дүүрэг
ХУД	Хан-Уул дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
ХАӨБД	Хүн ам өрхийн бүртгэлийн дэвтэр
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нийслэлийн нохой муурны тоо, жилийн эцсийн байдлаар .....	11
Хүснэгт 2. Тэжээвэр амьтдын тоо, дүүргээр, 2020 он.....	11
Хүснэгт 3. Судалгааны хамрах хүрээ тодорхойлох тооцоо, 2021 оны жилийн эцсийн байдлаар .....	17
Хүснэгт 4. Хан-Уул дүүргийн орон сууцны хороодын тоо, 2022.01.01-ний байдлаар.....	18
Хүснэгт 5. Сонгинохайрхан дүүргийн орон сууцны хороодын тоо, 2022.01.01-ний байдлаар ....	18
Хүснэгт 6. Багануур дүүргийн орон сууцны хороодын тоо, 2022.01.01-ний байдлаар .....	19
Хүснэгт 7. Судалгааны түүврийн хэмжээ, хамралт.....	19
Хүснэгт 8. Гэртээ амьтан тэжээдэг хөршүүдийн учруулдаг хүндрэл,эрэмбэлсэн байдлаар, хувиар .....	26
Хүснэгт 9. Гэрийн тэжээвэр амьтан тэжээх болсон шалтгаан, төрлөөр, хувиар.....	27
Хүснэгт 10. Гэрийн тэжээвэр амьтны гэрчилгээ авсан болон вакцин, тарилга хийлгэсэн байдал, төрлөөр.....	28
Хүснэгт 11. Гэрийн тэжээвэр амьтнаа эмнэлэгт үзүүлсэн байдал, дүүргээр, хувиар.....	28
Хүснэгт 12. Гэрийн тэжээвэр амьтнаа эмнэлэгт үзүүлсэн байдал, амьтны төрлөөр, давтамжаар .....	29
Хүснэгт 13. Гэрийн тэжээвэр амьтныхаа ариун цэврийг сахиулдаг байдал, давтамжаар, хувиар .....	29
Хүснэгт 14. Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхтэй холбоотой заавал мөрдөх аюулгүй байдлын журам, стандартыг талаарх иргэдийн мэдлэгийн байдал .....	30
Хүснэгт 15. Заавал мөрдөх аюулгүй байдлын журам, стандартын талаарх мэдээллийг авсан эх сурвалж, хувиар.....	30
Хүснэгт 16. Гэрийн тэжээвэр амьтантай болон амьтангүй хүмүүсийн стандартын талаарх санал бодол.....	31
Хүснэгт 17. Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээх, оршин суугчдын аюулгүй байдлыг хангах хотын стандартын заалтад оруулах санал, давтамжаар, хувиар .....	31
Хүснэгт 18. Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээж байгаа нь оршин суугчдын аюулгүй байдал, орон сууцны гадна орчинд учруулж байгаа хүндрэл, шалтгаанаар .....	32
Хүснэгт 19. Хотын стандартад оруулах зарим заалт, эрэмбэлснээр.....	33
Хүснэгт 20. Гадаадын зарим орнуудын нохой муурны тоо, 2016 он, сая .....	35

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нохойны тоо дүүргээр, хувиар.....	11
Зураг 2. Муурын тоо дүүргээр, хувиар.....	11
Зураг 3. Амьтны эмнэлэгүүд .....	14
Зураг 4. Орон сууцны гадна орчин.....	14
Зураг 5. Түүвэрлэлтийн үе шатууд.....	17
Зураг 6. Албан ёсны статистикийн мэдээ өгдөг сууц өмчлөгчдийн холбоодын тоо, дүүргээр..	19
Зураг 7. Мэдээлэл цуглуулах хэлбэрүүд.....	24
Зураг 8. Дүүргүүдийн Статистикийн хэлтэс дээр ажиллаж байгаа нь.....	25
Зураг 9. Гэрийн тэжээвэр амьтан тэжээдэг болон тэжээдэггүй өрхийн тоо.....	26
Зураг 10. Гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд гарч байгаа хүндрэл, хувиар.....	27
Зураг 11.Тэжээвэр амьтнаа салхилуулахдаа ялгадасаа цэвэрлэдэг эсэх, шалтгаанаар, хувиар .....	28
Зураг 12. Үржил хязгаарлах мэс засал буюу спэй хийлгээгүй шалтгаан, хувиар.....	30
Зураг 13. Гадаадын зарим орнуудын загас, гоёлын шувууны тоо, сая.....	35
Зураг 14. Нохойны ялгадасны сав, БНХАУ, Бээжин хот.....	36
Зураг 15. Нохойн ялгадасны сав, Ирланд улс. 2022.10 сар .....	38

## ХУРААНГУЙ

Монгол улс нүүдлийн соёл иргэншлээс суурин амьдралд шилжиж, хотжих үйл явц эрчимжсэнтэй холбоотойгоор нохой, муур болон гэрийн тэжээвэр амьтан тэжээх, үржүүлэх тохиолдол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, суурин соёл иргэншилтэй гаднын улс орны жишгээр гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалт, дүрэм журам, хотын стандартыг тогтоон мөрдүүлэх зүй ёсны шаардлага бий болж байна.

Манай улсын хувьд эдийн засгийн үр ашигтай гахай, шувуу, таван хошуу малыг тоолдог ч гэрийн тэжээвэр амьтад болон нохой, муурын албан ёсны нэгдсэн тооллогыг хийдэггүй байна. Мөн тэжээвэр амьтдын нөхцөл байдлын талаар судалгаа хийгдсэн байдаг ч орон сууцанд тэжээвэр амьтан тэжээх, оршин суугчдын эрүүл, аюулгүй байдлыг хангахтай холбоотой, стандарт талаас нь судалсан судалгаанууд улс, нийслэл, дүүргийн хэмжээнд хараахан хийгдээгүй байна.

Энэхүү суурь судалгааны ажлын хүрээнд нийслэлийн орон сууцны тэжээвэр амьтад оршин суугчдын хүрээлэн буй орчин, тав тух, эрүүл, аюулгүй амьдрах орчинд нөлөөлж байгаа эсэх, оршин суугчдын болоод тэжээвэр амьтдын эрх ашиг, хэрэгцээ шаардлага, эрх үүрэг, хариуцлагыг зохицуулсан хотын стандартыг тогтоон мөрдүүлэх шаардлагатай эсэхийг судлахыг зорьсон болно.

Судалгааг энгийн санамсаргүй түүвэрлэлтийн аргаар хийсэн бөгөөд Улаанбаатар хотын 5 дүүргийн орон сууцны хороололд гэрийн тэжээвэр амьтан тэжээдэг болон тэжээдэггүй гэсэн нийт 2161 өрх, 80 сууц өмчлөгчдийн холбоог хамруулан тоон судалгааг хийж гүйцэтгэн үр дүнг гаргалаа.

Судалгааны үр дүнгээс харахад, өрхийн судалгаанд оролцогчдын 73.5 хувь, сууц өмчлөгчдийн холбоодын 86.0 хувь нь оршин суугчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд Улаанбаатар хот стандарттай байх шаардлагатай гэж үзсэн байна.

Судалгаанд хамрагдсан өрх, сууц өмчлөгчдийн холбоодоос хотын стандартыг тогтоон мөрдүүлэх асуудалд орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд нэмэлт төлбөр хураамжтай болох, орон сууцны гадна талд гэрийн тэжээвэр амьтан салхилуулах зориулалтын талбайтай болох, том хэмжээтэй нохой болон гаршуулсан зэрлэг амьтдыг орон сууцанд тэжээхгүй байх, иргэдийн гэртээ амьтан тэжээх талаар мэдлэгийг дээшлүүлэх, орон сууцанд тэжээж байгаа гэрийн тэжээвэр амьтны эрүүл мэнд, аюулгүй байдал, тав тухыг хангах талаарх заалтуудыг тусгуулахаар саналаа өгсөн байна.

Судалгааны үр дүнд үндэслэн тэжээвэр амьтантай холбоотой хотын стандартыг батлуулан, энэ талаарх мэдээ, мэдээллийг олон сувгаар тухай бүр түгээх, орон сууцны гадна талд гэрийн тэжээвэр амьтан салхилуулах зориулалтын талбайтай болох асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай юм.

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ .....	i
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ .....	ii
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	iii
ХУРААНГУЙ.....	iv
1. ОРШИЛ.....	6
1.1 Судалгааны үндэслэл.....	8
1.2 Судалгааны зорилго .....	9
2. СУДАЛГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	10
2.1 Мэдээлэл, статистик үзүүлэлт .....	10
2.2 Хууль эрх зүйн орчин .....	12
2.3 Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандартууд .....	12
2.4 Нийслэл дэх мал эмнэлгийн үйлчилгээ .....	13
3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	16
3.1 Судалгааны хамрах хүрээ .....	17
3.2 Судалгааны түүвэрлэлт .....	17
3.3 Суурь судалгааны асуулга.....	19
3.4 Судалгааны мэдээлэл боловсруулалт, шинжилгээ.....	23
3.5 Судалгааны хязгаарлагдмал байдал.....	23
4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН .....	24
4.1 Өрхийн судалгааны үр дүн .....	25
4.2 Сууц өмчлөгчдийн холбооны судалгааны үр дүн .....	32
4.3 Гадаад орнуудын туршлага .....	34
5. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ .....	40
5.1 Судалгааны дүгнэлт.....	40
5.2 Санал, зөвлөмж.....	40
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	45
ХАВСРАЛТ.....	46

## 1. ОРШИЛ

Монголчууд эрт дээр үеэс нохойтой нөхөрлөж, хашаа, хотоо хамгаалуулж ирсэн түүхтэй. Монголчуудын дунд суурин соёл иргэншил нэвтэрч эхэлснээр гэр орондоо нохой, муур болон бусад амьтдыг тэжээх явдал нэмэгдэж, сүүлийн жилүүдэд тансаг хэрэглээ тал руугаа шилмэл үүлдрийг сонгон тэжээх, нутагшуулах хандлага ажиглагдаж байна.

Манай улсын хувьд эдийн засгийн үр ашигтай гахай, шувуу, таван хошуу малыг жил бүр тоолдог ч гэрийн тэжээвэр амьтад болох муур, нохойны албан ёсны нэгдсэн тооллогыг хийдэггүй. Тиймдээ ч нэгдсэн тоон мэдээлэл, түүнд үндэслэсэн бодлого, хяналт бага байдаг. Тухайлбал, орон сууц өмчлөгчдийн холбоод гэрийн тэжээвэр амьтдыг бүрэн бүртгэдэггүй, хороодын засаг дарга нар бүртгэдэг ч анхан шатны мэдээллийн үнэн бодит байдал хангалтгүй байна.

Эрүүл мэндийн байгууллагын статистик мэдээллээр нохойнд уруулсан /гэмтсэн/ яаралтай тусламжийг өдөрт 6-8 хүнд үзүүлдэг байна. Энэ бол зөвхөн гэмтлийн эмнэлэгт очсон тохиолдол юм. 2020 онд нохойд хазуулсан шалтгаанаар эмнэлэгт хандсан 3.8 мянган тохиолдол бүртгэгдсэн бөгөөд эдгээр тохиолдлын 37.0 орчим хувь нь 0-15 насны хүүхдүүд байсан байна. 2021 оны эхний хагас жилд 1421 хүн нохойд хазуулсан шалтгаанаар ГССҮТ-д ирсэн байна. Үүний 266 нь 5-9 насны хүүхэд байна.

ГССҮТ-ийн статистик мэдээллээс харахад нохойнд хазуулж гэмтсэн хүмүүсийн 80 орчим хувь нь гэрийн тэжээвэр нохойнд уруулдаг байна. **Нохой тэжээгчдээс тэжээдэггүй хүмүүсийн шаарддаг зүйл нь нохойгоо хошуувчтай явуулахыг байнга сануулдаг бол тэжээгчид нь гэмгүй, хүн хаздаггүй үүлдрийн гэх зөвтгөлөөр үгүйсгэдэг.**

Тиймээс нохой тэжээгчид үүрэг хариуцлагаа ухамсарлаж, тодорхой үүрэг хариуцлага хүлээх холбогдох стандарт журмыг тогтоон мөрдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна. **Монгол Улсын иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.1 Амьтны үйлдлээс хүний амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорыг тухайн амьтныг өмчлөгч буюу эзэмшигч хариуцна. гэж заасан хэдий ч иргэд ихэнх тохиолдолд тухайн нохойн эзэн хохирогчид эм тариа авч өгөх, эсхүл эмчилгээнд шаардлагатай мөнгийг өгч зохицдог. Зарим тохиолдолд тоолгүй хаяад явах нь ч цөөнгүй гардаг. Хууль шүүхийн байгууллагад хандаж, шийдүүлсэн тохиолдол маш цөөн байдаг байна.**

Аюулгүй байдал ба амьтны эрхийг хамгаалах хуулийн нарийн зохицуулалт байхгүй ч Эрүүгийн хуульд энэ талаар хоёр заалт бий.

### **20.15 дугаар зүйл.Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах**

Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгасны улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

Энэ гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Иймийн тул хэрэв таны нохой бусдыг хазаж, гэмтээсэн бол даруй хохирогчид эмнэлгийн тусламж үзүүлж, хохирлыг нөхөн төлөх нь зүйтэй юм.

Нийслэлийн Хот тохижилтын газраас өнгөрсөн жил 100 мянган нохой, муур устгахаар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар нийт 97 мянган нохойг агнажээ. Жил бүр нохой устгах буюу буудаж агнах ажиллагаанд нийслэлээс 800 саяас нэг тэрбум хүртэл төгрөг зарцуулдаг боловч төдийлөн үр дүнгээ өгдөггүй байна. Энэ нь нэг охин нохой зургаан жилд хамгийн багадаа 6700 болж үрждэгтэй холбоотой. Охин нохойны ороо жилд хоёр удаа орж, хээлтдэг. Нэг удаагийн төрөлтөөр 6-12 гөлөг гаргадаг гэж тооцвол хоёр жилийн дотор 100, зургаан

жилийн дотор 6700-67000 болж үржинэ гэж амьтны мэргэжилтнүүд хэлж байна. Харин 150 нохойд үржил хаах мэс засал буюу спэй хийснээр 2020 онд 75 мянга болж үржих байсан золбин нохдыг устгасантай дүйцнэ.

Улсын төсвөөс нэг муурыг устгахад 12 мянган төгрөгийн төсөв төсөвлөдөг. Нохойд ч мөн ялгаагүй тэр багцааны зардал төсөвлөдөг аж. Хэдэн зуун мянгаараа тоологдох тэр их амьтдыг зэрлэг аргаар буудаж тэмцэж байгаа нь өнөө цагт хэтэрхий мунхаг үйлдэл ч гэж хэлж болох. Гэвч иргэдийн аюулгүй байдлыг бодолцож үзсэний үндсэн дээр үүнийг хийхээс өөр арга байхгүй тухай албаныхан учирлаж байна. Багцаа тоогоор нийслэлд жилдээ 1.2-1.8 тэрбум төгрөг муур, нохойн устгалд зарцуулагддаг. Зөвхөн устгаад зогсохгүй сэг зэмийг нь бүрэн устгахад 130 сая төгрөг зарцуулдаг гэсэн тоо ч байна. Хэрвээ тэр их сэг зэмийг устгаж чадахгүй бол хөрсний бохирдлыг маш аюултай төвшинд аваачдаг аж. Зөвхөн Улаанбаатар хотод 80-100 мянган нохойг буудаж хогийн цэг дээр булдаг. Тэнд ямар ч өвчтэй нохой, буудуулсан байж болно. Тэр сэг зэм ялзарч, өмхийрч байгаа. Харин бид тэр агаараар амьсгалж байна. Энэ нь нийтийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас нийслэлийн Мал эмнэлгийн газар болон бусад төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн мал эмнэлгийн газруудтай хамтран өнгөрсөн хоёр жилийн хугацаанд 4000 гаруй хашааны нохойд үржил хаах мэс заслыг үнэ төлбөргүй хийж өгчээ. Энэ ажлыг нийслэлийн Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт хэрэгжүүлсэн байна. Гэр хорооллын оршин суугчдын тухайд спэй заслагын талаар ойлголцгоүй, энэ талаар мэдээлэлтэй байсан ч эдийн засгийн боломж хомс г.м шалтгааны улмаас энэ төрлийн үйлчилгээнд хамрагддаггүй байна.

Монголчууд урьдын хоточ банхараа тэжээдгээс ондоогоор, орон гэртээ нохойгоо тэжээдэг болсон төдийгүй бүр үр хүүхэд шигээ ханддаг болсонд ч гайхах зүйлгүй. Энэ бол гадаадаас орж ирсэн бас нэгэн соёл. Ингэхдээ үүлдэрт нь ач холбогдол өгдөг ч үүсэл, удамд нь анхаарал төдийлөн хандуулдаггүй. Сайн дурын үржүүлэгчид, амьтны дэлгүүрт ашиг олох боломж олгож, тэр тоолонгоор илүү олон асуудал гарах болсон талаар мэргэжлийн хүмүүс анхааруулж байна. Эцэг эхчүүд хүүхдийнхээ хүслийг биелүүлэх гэж нохой авснаас болоод хэсэг хугацааны дараа хүүхдийн сонирхол буурч, арчилж чадахгүй болоод ирэхээрээ өөр хүнд өгдөг, болохгүй бол гудамжинд гаргадгаас олон үүлдрийн нохой золбирах нь олширчээ. Мөнгө олохын тулд нохой үржүүлэгчдийн балгаар цэвэр цусны, сайн чанарын үүлдэр Монголд тун чиг цөөхөн аж. Мэдээж цэвэр цусных биш учраас тухайн үүлдрийн онцгой шинж, зан чанар, хэлбэр хүртэл алдагддаг. Энэ нь мэдээж саар үр дагавар авчрах нь ойлгомжтой. Нохой үржүүлэгчид ашиг олохын тулд наад зах нь цэвэр цустай эсэх, цаашлаад удмын бичигт ач холбогдол өгдөггүй. Нэгэнт гаргаж авсан үүлдрээсээ өөр цустай холилдсон болохоор зан байдал, характерт нь ч өөрчлөлт орох нь тодорхой. Тиймээс хүүхдэд ээлтэй, гэр бүлийн гэгддэг нохойнууд эзнээ хазсан, дайсагнасан үйлдлүүд гаргасан талаар элбэг дуулдаг.

Өөр нэгэн гаж үзэгдэл нь гадаадад тусгай зөвшөөрлөөр тэжээдэг, үржүүлдэг амьд зэвсэг гэж хэлж болохуйц үүлдрийг Монголд хэн дуртай нь тэжээж байна. Дундад ази, кавказ овчарка, доберман, ротвейлер, Түвд банхар, питбультерьер, акита инү, маламут, хаски, боксер, чау чау, дог аргентино гэхчлэн аюултай нохдыг гудамжинд хошуувч, хөтөлгөөгүй дагуулж явах нь манайд энгийн үзэгдэл. Түрэмгий авиртай, хүч чадал ихтэй эдгээр нохдыг ямар ч сургуулилтгүй, буруу тэжээсэн тохиолдолд эзэндээ ч хөнөөлтэй. Тэр дундаас питбультерьер, бульдог, мастиф, кавказын хоньч зэрэг зарим улс оронд тэжээхийг хориглосон үүлдэр ч хэд хэд бий. Зодооны, хамгаалалтын зориулалтаар ашигладаг нохойг гадаадад тусгай зөвшөөрөлтэй байгууллага үржүүлдэг бол зөвхөн тусгай зөвшөөрөлтэй этгээдэд аюулгүй байдлыг нь хангасны үндсэн дээр тэжээхийг зөвшөөрдөг ч гудамж талбайд дур зоргоороо хөтлөөд явахыг хориглодог. Тиймээс энэ төрлийн нохойг нарийн хяналтын дор тусгай зөвшөөрлийн эрхтэйгээр тэжээдэг, үржүүлэхийг хориглодог хууль эрх зүйн актууд үгүйлэгдэж байна. “Анхаар нохойтой” гэдгээс илүүтэй аюулгүй байдлыг нь хариуцдаг тусгай зөвшөөрөл өнөөдөр үгүйлэгдэж байна. Нохойг хэн дуртай нь бус зөвхөн тусгай зөвшөөрлөөр үржүүлдэг, зардаг болох хэрэгтэй.

“Амьтад Амьдрах Эрхтэй” төслийн хүрээнд хуулийн ач холбогдол үр нөлөөг олон нийтэд сурталчлан таниулах ажлууд хийгдэж байгаагийн зэрэгцээ Монгол улс дахь тэжээвэр амьтдын нөхцөл байдлын суурь судалгааг анх удаа хийж, олон улсын туршлагад үндэслэн жишиг хуулийн төслийн загвар боловсруулсан байна.



Иймээс олон улсын стандартад нийцсэн гэрийн тэжээвэр амьтан тэжээх журам, стандарттай болох, амьтан тэжээх хүмүүст тавигддаг шаардлагыг нэмэгдүүлэх, хариуцлага тооцдог болох, хяналтгүйгээр үржүүлэх, амьтанд харгис хэрцгий хандаж байгааг зогсоох, тоо толгойг нь багасгахын тулд буудаж устгах аргыг өөрчлөх зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хууль, эрх зүйн орчин зайлшгүй хэрэгтэй байгаа юм.

## 1.1 СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Суурьшлын бүс дэх тэжээвэр амьтантай холбоотой асуудал нь орон сууцанд амьтан тэжээдэг эрх, тэдгээрийн хөршүүдээс гадна тэдэнд үйлчилгээ үзүүлдэг, судалгаа шинжилгээ хийдэг, тэдгээртэй эдийн засаг, нийгмийн хүрээнд харилцан холбогдож, харилцаанд ордог төрийн болон төрийн бус байгууллагуудын бүхий л хүрээг хамран, эрх үүрэг, харилцаа, хүлээх хариуцлагыг тодорхой болгосон дүрэм журам, стандартыг тогтоон мөрдүүлснээр иргэдийн болоод тэжээвэр амьтдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа мал амьтантай холбоотой хууль тогтоомж, хөтөлбөрүүдэд мал, тэжээвэр амьтны эрүүл мэнд, иргэний эрх үүрэг, орчны эрүүл ахуй, эмчилгээ, үйлчилгээ, өвчлөл, хоол хүнс, аюулгүй байдал, орчны цэвэрлэгээ үйлчилгээ, тооллого судалгаа, бүртгэлжүүлэх, мэдээллийн сан байгуулах зэрэг харилцааг зохицуулсан байдаг. Харин нохой, муур зэрэг гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцааг зохицуулах хууль эрх зүйн акт одоогоор хангалтгүй байна.

Хүний эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн байгаа орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг үр дагаврыг бууруулах, арилгахтай холбогдсон хотын стандарт, норм, дүрэм бий болгоход өнөөгийн байдлын суурь судалгааг хийх зайлшгүй шаардлагатай болсон. Энэхүү судалгааг хийхдээ:

- Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”
- Засгийн газрын 2016 оны 344 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт “Үндэсний чанарын хөтөлбөр”
- “Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх” таван жилийн үндсэн чиглэл
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”

зэрэг хууль эрх зүйн баримт бичгүүдийг үндэслэл болгон ажиллалаа.

Орон нутгийн захиргааны байгууллагуудаас өөр, өөрсдийн онцлогт тохирсон төсөл, арга хэмжээг нутаг дэвсгэрийн хүрээнд авч хэрэгжүүлэн, тодорхой дүрэм журмыг батлан мөрдөж ажилласан байна. Тухайлбал:

- Нийслэлийн нутаг дэвсгэрт нохой муур тэжээх, арчлах, золбин нохой муур устгахад мөрдөх журам /Улаанбаатар хот/
- Нохой муурыг бүртгэлжүүлж, мал эмнэлгийн цогц арга хэмжээнд хамруулах, үржлийг мэс заслын аргаар хязгаарлах төсөл /Дархан-Уул аймаг/
- Нохой тэжээх, арчлах, золбин нохой устгахад дагаж мөрдөх журам /Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум/

Үндэсний Статистикийн хороо, Нийслэлийн Статистикийн газар болон дүүргийн Статистикийн хэлтсээс гаргаж буй албан ёсны статистик тоо мэдээлэлд тэжээвэр амьтнаас үүдэлтэйгээр иргэдийн аюулгүй байдал алдагдаж буй талаар хийсэн судалгааны ажил, дүн шинжилгээ, тоо мэдээлэл одоогоор байхгүй байна.

Мал, тэжээвэр амьтдын тооллогоор тоологдсон тэжээвэр амьтдын тоо нь дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо, нийт үйлдвэрлэлийг тооцоолох мэдээллийн эх үүсвэрийг бий болгох, сайжруулахад ашиглагддаг. Энэ тооллогын дүнгээс орон сууцны хороололд тэжээж байгаа амьтдын тоон мэдээлэл гарах боломжгүй юм. Нийслэлийн хороодод хөтлөгддөг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн тухайн өрхийн үзүүлэлт хэсэгт “мал, тэжээвэр амьтантай эсэх” гэсэн асуулт зөвхөн тийм, үгүй гэсэн хариулттай байгаа нь өнөөгийн мэдээллийн эрэлт хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.

Нийслэлийн Мал эмнэлгийн газар нь нийслэлийн нутаг дэвсгэрт мал, амьтан болон тэдгээрийн гаралтай хүнсний бус түүхий эдийн худалдаа эрхлэхэд тавигдах мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагыг мөрдүүлэн ажилладаг бөгөөд амьтан худалдаалах зориулалтын дэлгүүр, нийслэлийн нутаг дэвсгэрт гэрийн тэжээвэр амьтны үзэсгэлэн худалдаа, нохойн тэмцээн уралдаан зохион байгуулах, гэрийн тэжээвэр амьтныг үржүүлэх газар, түр асрах байрны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг зохих журмын дагуу олгодог.

Улаанбаатар хотод 14 амьтны эмнэлэг ажиллаж байна. Амьтны эмнэлэг нь гэрийн тэжээвэр амьтан тэжээгчдэд зөвлөгөө өгөх, эмчлэхээс гадна гэрийн тэжээвэр амьтныг эзэнгүй хаях, нохойгоо буруу дадал, зан араншинд сургасан гэх мэт хайхрамжгүй хандлагыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөн гэрийн тэжээвэр амьтны эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, вакцинжуулалт, амьтныг ялган тэмдэглэх, эзэн нь олдохгүй үед түр хамгаалах, гэрийн тэжээвэр амьтныг засах, унтуулах ажил үйлчилгээг үзүүлдэг байна.

Нийслэлийн орон сууцны байрнуудын гадна талд авто зам, ногоон байгууламжийн талбай, хүүхдийн тоглоомын талбай, сагсны талбай зэрэг байгууламжуудад гэрийн тэжээвэр амьтан салхилуулах, гүйж харайхад зориулсан талбай байдаггүй. Олон улсын жишгээр эдгээр талбайнуудад амьтан салхилуулахыг зөвшөөрдөггүй байна.

Гэрийн тэжээвэр амьтан тэжээгчид албан ёсны бүртгэлгүй, тэдгээрт тусгай шаардлага тавьдаггүй, хариуцлага тооцох эрх зүйн орчин байхгүйгээс гэрийн тэжээвэр амьтадтай зүй бус харьцах, амьтны эрхийг зөрчих, эзэнгүй амьтны тоо толгойг нэмэгдүүлэх, бусдын бие мах бодид гэмтэл учруулах зэрэг иргэдийн хариуцлагагүй байдал нь орчны аюулгүй байдал, иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Гэрийн тэжээвэр амьтан ялангуяа нохой, муур тэжээгч /өмчлөгч/-ийг илүү хариуцлагатай байхыг урамшуулан дэмжсэнээр нохой, муур золбирах зохисгүй хандлагыг бууруулж, нохой муурын эрүүл мэнд, тав тухтай орчинд амьдрах нөхцөл байдлыг сайжруулснаар хүнд учруулах эрсдэлийг бууруулна. Нохой муурын хариуцлагатай өмчлөлийг хууль тогтоомж, боловсролоор дамжуулан сурталчлан таниулах хэрэгтэй байна.

Энэхүү судалгаагаар орон сууцны байранд тэжээвэр амьтан тэжээхэд орчиндоо үзүүлж буй нөлөөллийг судлахыг зорьсон бөгөөд Улаанбаатар хотын суурьшлын бүс дэх тэжээвэр амьтдын орчны нөлөөллийн мэдээлэлд үндэслэн хотын стандарт, норм, дүрмийг бий болгох боломж бүрдэх юм.

## **1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО**

Судалгааны гол зорилго нь Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг болон үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангах, хүн амын ажиллаж, амьдрах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, гэрийн тэжээвэр амьтны хотын стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулахад оршино.

Энэхүү суурь судалгааг явуулснаар:

- Нийтийн орон сууцанд тэжээвэр амьтан тэжээхэд хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, амьдрах орчинд үзүүлж буй хүндрэл бэрхшээл
- Суурьшлын бүсэд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд стандарт шаардлагатай эсэх асуултад хариулт авахыг зорьсон.

## 2. СУДАЛГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 2.1 МЭДЭЭЛЭЛ, СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

Нийслэлийн Статистикийн газар болон дүүргийн Статистикийн хэлтсээс жилд нэг удаа явагддаг нохой муурын тоо бүртгэл, мал, тэжээвэр амьтдын тооллогын дүнгээр тэжээвэр амьтдын тоон мэдээллийг хэрэглэгчдэд тархаадаг.

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн дагуу захиргааны мэдээлэл цуглуулах зорилгоор анх нийслэлийн Засаг даргын 2005 оны 475 дугаар захирамжаар нохой муурын бүртгэлийг бий болгож, Үндэсний статистикийн хорооны даргын 2005 оны 01/136 дугаар тушаалаар баталгаажуулснаар албан ёсны статистик мэдээний нэг болсон байна.

Дүүргүүдийн Статистикийн хэлтэс нь жилд нэг удаа хороодоос нохой, муурын бүртгэлийг батлагдсан маягтын дагуу заагдсан хугацаанд гаргуулан авч, Нийслэлийн статистикийн газар нийслэлийн хэмжээнд мэдээллийг нэгтгэн, нийслэлийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хэрэглэж ирсэн байна. (Хавсралт 2. Нийслэлийн Засаг даргын 2005 оны 475 тоот захирамж, Хавсралт 3. Үндэсний Статистикийн хорооны даргын тушаал)

"Азтай савар амьтанд хайртай залуус" ТББ-ын захиалгаар Y-Insight судалгааны байгууллагын хийсэн "Монгол Улс дахь тэжээвэр амьтдын нөхцөл байдлын суурь судалгаа"-ны тайлангаас харахад гэрийн тэжээвэр амьтны тоо жилээс жилд өсөх хандлагатай байна.

2021 онд хийгдсэн судалгаагаар нийслэлийн орон сууцны хороололд 22 мянга, гэр хороололд 77 мянга, нийт 99 мянган гэрийн тэжээвэр нохой байдаг гэсэн тооцоо хийсэн байна. Өөрөөр хэлбэл нийслэлд бүртгэлтэй нохойны дөрөвний гурав нь хашаанд амьдардаг байна.

Улсын хэмжээнд 250 мянган өрх гэрийн тэжээвэр амьтантай гэсэн албан бус тоо байдгаас дийлэнх нь нохой, муур байна. Амьтан тэжээдэг өрхийн 83.0 хувь нь нохой, 23.0 хувь нь муур тэжээдэг байна. Мөн нийт өрхийн 25 хувь нь гэрийн тэжээвэр амьтантай. Үүнээс орон сууцны хорооллын өрхийн 12 хувь, гэр хорооллын өрхийн 34 хувь нь амьтан тэжээдэг гэсэн байна. Дээрх судалгаагаар иргэд гэртээ амьтан тэжээх болсон шалтгаанаа ихэвчлэн өөрийгөө болон гэрээ хамгаалуулахаар, амьтанд хайртай, хүүхдүүдийн хүсэлтээр, өхөөрддөг учраас зэргээр тайлбарлажээ.

Гэрийн тэжээвэр амьтантай иргэд нь тэжээвэр амьтантай байхын давуу талыг гэр бүлийн гишүүдийг хариуцлагатай байдалд сургадаг, гэр бүлд халуун дулаан уур амьсгал авчирдаг, ганцаардуулахгүй ханьтай байдаг, гадуур явахад гэр орныг нь хамгаалдаг гэж түлхүү хариулсан байна.

Гэвч зарим иргэд хүүхдээ нохой нэхэхээр сэтгэлийн хөдөлгөөнөөр авч өгчхөөд хүүхдүүд нь уйдаг, эсвэл өөрсдөө зааж, сургаж, анхаарал халамж тавьж чадахгүйгээс болж, нохойгоо гаргаж хаях, төөрүүлэх тохиолдол гардаг байна.

Амьтны эрүүл, аюулгүй орших шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд тэжээвэр амьтан байлгах нь амьтны эрүүл мэндэд ч хортой. Амьтан тэжээх нь анхаарал халамж, цаг хугацаа шаардсан нялх хүүхэд асрахаас дутахааргүй үүрэг хариуцлагатай гэдгийг ухамсарлах хэрэгтэй. Уг хариуцлагыг нэмэгдүүлэхэд эрх зүйн орчин шаардлагатай байгааг судалгааны мэргэжилтнүүд анхааруулсан байна.

Нийслэлийн Статистикийн газар болон дүүргүүдийн Статистикийн хэлтэс нь 2005 оноос нохой, муурын бүртгэлийн мэдээллийн динамикийг бүрдүүлж ирсэн. (Хавсралт 3. Гэрийн нохой, муурын бүртгэлийн маягт)

Нийслэлийн нохой, муурын сүүлийн 9 жилийн харьцуулсан статистик судалгааг доорх хүснэгтээр харуулав. Үүнд, нийслэл хотод 2013 онд 66.0 мянган нохой, 1379 муур бүртгэгдэж байсан бол 2021 оны байдлаар 55.1 мянган нохой, 1981 муур бүртгэгдсэн байна.

Улаанбаатар хотод 2017 онд 66.5 мянган нохой, 2018 онд 66.9 мянган нохой бүртгэгдэж нохойны тоо нэмэгдэж байсан бол 2019 оноос нохойны тоо буурсаар 2021 онд 55.1 мянган нохой бүртгэгдсэн байна.

2016 онд 1530 муур бүртгэгдсэн нь 2013 оноос 151-ээр буюу 11.0 хувиар нэмэгдсэн байна. 2017 онд 1320 муур бүртгэгдсэн бол 2018 оноос муурын тоо өссөөр 2021 онд 1981 мууртай болсон буюу энэ нь 2017 оноос 50.1 хувиар өссөн байна. Энэхүү тоо мэдээлэлд золбин нохой, муур бүртгэгдээгүй.

Хүснэгт 1. Нийслэлийн нохой муурын тоо, жилийн эцсийн байдлаар

Он	Нохойн тоо									
	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	
Нийслэлийн дүн	66048	66636	67536	67932	66097	61002	57002	55506	55121	
Он	Муурын тоо									
	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	
Нийслэлийн дүн	1379	1330	1418	1530	1320	1432	1455	1539	1981	

Эх сурвалж: Нийслэлийн Статистикийн газар

Зураг 1. Нохойны тоо дүүргээр, хувиар



Зураг 2. Муурын тоо дүүргээр, хувиар



Монгол Улсын Статистикийн хуулийн дагуу жил бүрийн 12 дугаар сард мал, тэжээвэр амьтдын жилийн эцсийн тооллогыг зохион байгуулдаг бөгөөд уг тооллогоор тэжээвэр амьтдыг хамт тоолдог.

2020 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор гахай 8983, шувуу 566.8 мянга байгаагаас 566.2 мянган тахиа, 364 туулай, 44 минж, 2 зөгийн бүл тоологдсон байна. (Хавсралт 5. Мал тэжээвэр амьтдын тооллогын маягт)

Хүснэгт 2. Тэжээвэр амьтдын тоо, дүүргээр, 2020 он

Дүүрэг	Тэжээвэр амьтан					
	Гахай	Шувуу	Үүнээс:Тахиа	Туулай	Минж	Зөгийн бүл
Нийслэл	8983	566852	566151	364	44	2
Багануур	31	57	28			2
Багахангай	26	2				
Баянгол		18	18	4		
Баянзүрх	125	5428	5343	11	44	
Налайх	135	132716	132687	10		
Сонгинохайрхан	4783	581	498	56		
Сүхбаатар	36	420	356	12		
Хан-Уул	3847	427437	427062	240		
Чингэлтэй		193	159	31		

Эх сурвалж: Нийслэлийн Статистикийн газар

Мал, тэжээвэр амьтдын тооллогоор тоологдсон тэжээвэр амьтдын тоо нь зөвхөн дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо, нийт үйлдвэрлэлийг тооцоход мэдээллийн эх үүсвэрийг бий болгох, сайжруулах зэрэг эдийн засгийн тооцоонд ашиглагдах зорилгоор хийгддэг. Энэ тооллогын дүнгээс орон сууцны хороололд тэжээж байгаа амьтдын тоо мэдээлэл гарах боломжгүй юм.

Улаанбаатар хотын хороодод хөтлөгддөг хүн ам өрхийн бүртгэлийн дэвтрийн тухайн өрхийн үзүүлэлт хэсэгт “мал, тэжээвэр амьтантай эсэх” гэсэн асуулт зөвхөн тийм, үгүй гэсэн хариулттай байгаа нь өнөөгийн мэдээллийн эрэлт хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна. (Хавсралт б. Хүн ам өрхийн бүртгэлийн дэвтэр)

## **2.2 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Монгол улсад мал, гэрийн тэжээвэр амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбоотой харилцааг “Амьтны тухай хууль”-аар мал, тэжээвэр амьтан, зэрлэг амьтны эрүүл мэндийг хамгаалах тэдгээрийн түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг “Мал амьтны эрүүл мэндийн хууль”-аар тус тус зохицуулж байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль нь мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, өвчингүй, тайван улс, бүс, нутаг, хот айл, аж ахуйн нэгжийг тогтоон баталгаажуулах үйл ажиллагаа, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэврийн үзлэг, лабораторийн шинжилгээ, мал эмнэлэг, хорио цээр, хязгаарлалтын хяналт, шалгалттай холбогдох харилцаанд үйлчилдэг. Харин гэрийн тэжээвэр амьтан буюу нохой, муур тэдгээртэй адилтгах бусад амьтадтай холбоотой асуудлыг зохицуулах хууль тогтоомж одоогоор гараагүй байна.

Тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл нь нийтийн эрүүл мэндийг хамгаалах, гэрийн тэжээвэр амьтныг бүртгэлжүүлэх, асран хамгаалах, түр харах, үржүүлэх, хүчирхийллээс хамгаалах, эзэнгүй амьтны тоог бууруулах зэрэг харилцааг зохицуулахаар боловсруулсан нь манай улсын хувьд гэрийн тэжээвэр амьтны тухай анхны хууль болох юм. Энэ хууль батлагдсанаар гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцаанд энэрэнгүй хандах, хүчирхийллээс ангид байлгах зарчим хэрэгжинэ.

Орчны эрүүл мэнд нь дэлхий дахинаа нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болсоор байна. Тиймээс, 2015 онд баталсан Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд нийт хүн амыг эрүүл, аюулгүй орчинд сайн сайхан амьдрах нөхцөлөөр хангах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг авахыг улс орнуудад зөвлөж байна.

Жил бүр дэлхий дахинд бүртгэгдсэн нийт нас баралтын 4 тохиолдол бүрийн 1 нь хүрээлэн байгаа орчны бохирдол болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой өвчний улмаас нас барж байна гэсэн статистик мэдээ байна. Үүнтэй холбоотойгоор хүн амын эрүүл мэнд, орчны эрүүл мэндийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна.

## **2.3 МОНГОЛ УЛСАД МӨРДӨГДӨЖ БАЙГАА СТАНДАРТУУД**

Аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны хангавал зохих наад захын хэм хэмжээг тогтоох нь стандарт юм. Стандартыг шинжлэх ухааны дэвшил, техник технологийн хөгжил, практикийн ололт амжилтад тулгуурлан боловсруулахаас гадна олон улсад хэдийн туршигдаж, батлагдсан стандартуудыг иш татах цаашлаад үндэсний стандарт болгох байдлаар тухайн улс орнууд өөрсдийн онцлогт тохируулан боловсруулж, нэвтрүүлдэг. Манай улсын хувьд Засгийн газрын тохируулагч агентлаг “Стандарт хэмжил зүйн газар” улсын хэмжээнд үндэсний болон олон улсын стандартуудыг мэдээлэх, арга зүйн зөвлөгөө өгөх, стандартыг баталж бүртгэх, аливаа салбар, үйл ажиллагааг стандартаар хангах зэрэг цогц үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлдэг эрх бүхий байгууллага юм.

Стандарт нь нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаа болох аливаа үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ гэх мэт харилцааг илүү цэгцтэй, нэгдмэл байлгах, аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд гол үндэс болдог. Улс орон болон байгууллага, хувь хүний нийгэм, эдийн засгийн хүрээнд тулгардаг бүх процесс, үйл ажиллагааг зохистой түвшинд журамлан, үр ашгийг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахад маш том хувь нэмэр болдог.

Монгол улсад тогтоон мөрдөж буй мал, тэжээвэр амьтад, тэдгээртэй холбоотой үйл ажиллагаанд ашиглаж буй стандартууд:

1. Стандарт хэмжил зүйн газраас баталсан Монгол Улсын мал, амьтны хүүр, сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэхэд тавих ерөнхий шаардлага, Мал амьтны үржүүлгийн бүтээгдэхүүнийг хадгалах, Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж ерөнхий шаардлага, Авто тээврийн хэрэгслээрээ мал, амьтан тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага зэрэг стандартууд нь ашиг шимийг нь хүртэх боломжтой мал, амьтдад зориулсан байна. (Хавсралт 1. Монгол улсын мал амьтантай холбоотой стандартууд)

2. Мал, амьтдын тэжээл, хүнсний ногоо, хиам, эмгэг эрхтэнд нитрит тодорхойлох, мал амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх үйл ажиллагаа эрхлэх, тусгай зөвшөөрөл олгох, байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах стандартууд байна. Мөн адуу, үхэр, тэмээ, хонь, ямаа, гахай, тахиа, зээр, чоно, нохой, ирвэс, муур зэрэг гэрийн тэжээвэр, зэрлэг, махчин амьтны махыг мал амьтны хүйсийг тодорхойлох стандартуудыг ашиглаж байна.

3. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлох, үйл ажиллагааны хүрээг тогтоох, үйлчилгээг тэгш, хүртээмж, чанартай явуулах нөхцөлийг хангах, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийхэд Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц үйл ажиллагаанд стандартыг ашигладаг.

4. Гэрийн тэжээвэр нохой, мууранд зориулсан хоол үйлдвэрлэхтэй холбоотой гэрийн тэжээвэр амьтны хоолны стандарт байна.

Дэлхийн амьтан хамгаалах нийгэмлэг нь амьтан хамгаалах хууль тогтоомж бодлогын дагуу улс орнуудын амьтныг хамгаалах индекс гаргадаг байна. Энэхүү индексээр мал амьтны эрхийг хамгаалсан зохицуулалт байгаа эсэх, гэрийн тэжээвэр амьтан тэр дундаа эзэнгүй амьтны эрхийг хамгаалсан зохицуулалт байгаа эсэх, амьтны эрхийг хамгаалах стандарт баримталдаг эсэхийг гол шалгуур үзүүлэлт болгодог байна.

Суурин соёл иргэншилтэй улс орнууд нохой, муур болон тэдгээртэй адилтгах амьтдыг гэр бүлийн гишүүн гэж үзэн гэрийн тэжээвэр амьтадтай холбоотой эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, гэрийн тэжээвэр амьтны эрхийг хуулиар баталгаажуулсан байдаг. Манай улсын хувьд хотжих үйл явц эрчимжсэнээс нохой, муур болон гэрийн тэжээвэр амьтан тэжээх, үржүүлэх тохиолдол нэмэгдэж байна.

## **2.4 НИЙСЛЭЛ ДЭХ МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

Нийслэлийн Мал эмнэлгийн газар нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц үйл ажиллагааны стандартыг баримтлан, дүүргүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлох, үйл ажиллагааны хүрээг тогтоох, үйлчилгээг тэгш, хүртээмж, чанартай явуулах нөхцөлийг хангах, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавин ажилладаг.

Манай улсад өнөөдрийн байдлаар нийт 20 гаруй амьтны эмнэлэг бүртгэгдсэний 14 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. (Хавсралт 7. Мал эмнэлгүүдийн мэдээлэл)

2021 оны статистикийн мэдээллээр Улаанбаатар хотод 55.0 мянган нохой муур бүртгэгдсэнээс 12.7 мянга орчим нохой, муур орон сууцны хороололд бүртгэгдсэн байна. Гэр байшин хороолол холимог хороодын нохой, муурын тоог салгах боломжгүй тул нийт дүнгээр нь оруулж тооцоход нийт үйл ажиллагаа явуулж байгаа амьтны эмнэлэгтэй харьцуулан харвал нэг амьтны эмнэлэгт 910 орчим нохой, муур ногдож байна.

Амьтны эмнэлгийг гурван зэрэглэлд хуваадаг ба тухайн амьтны эмнэлгийн үйл ажиллагаа явуулж байгаа байрны талбайн хэмжээгээр тооцож гаргадаг байна. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц үйл ажиллагааны стандартын 10 дахь заалтаар Нийслэлийн мал эмнэлгийн газар 3 жил тутам нэгжийн түвшнийг үнэлдэг байна.

Мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх мал эмнэлгийн зохистой үйлчилгээ хашаа байр, менежмент ба тэжээллэг болон аюулгүй орчин, хүмүүнлэг харьцаа, хүнлэг аргаар төхөөрөх, амь тэвчих замаар мал, амьтны сайн сайхан байдлыг хангах нь иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдүүлэх хүчин зүйлийн нэг юм.

Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа зарим амьтны эмнэлэг нь зориулалтын байртай боловч зарим амьтны эмнэлгүүд орон сууцны хонгилын давхарт байрлан үйл ажиллагаа явуулж байна. Амьтны эмнэлгүүд нь мал эмнэлгийн нэгжийн үйлчилгээ үзүүлэх

стандартын дагуу гэрийн тэжээвэр амьтныг эмчлэхээс гадна тэдгээрийг бичиг баримтжуулах, үзлэг, вакцин, туулгалт хийх зэргээр шаардлагатай эмчилгээ, үйлчилгээг үзүүлдэг байна.

Эдгээр амьтны эмнэлгүүд нь сүүлийн жилүүдэд гэрийн тэжээвэр амьтдад зөвхөн эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхээс гадна үс угаах засах, хумсыг нь авах зэрэг халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлж байна. Эмнэлгийн байрны гадна нохой, муур зэрэг амьтдыг орхих хаях явдал ихсэж байгаа нь тэдгээр хаягдсан амьтдыг эмчлэх, хооллох, асрах, эзэнтэй болгох гээд эмнэлгийн ажилд хүндрэл учруулдаг байна.

Зураг 3. Амьтны эмнэлгүүд



Хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэлтэй холбоотойгоор золбин нохойг хянах нь олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах үйл ажиллагааны нэг юм. Хүрээлэн буй орчны хяналтгүй байдлаас болж золбин нохойн популяци өсөн нэмэгдэж хүний эрүүл мэнд, амгалан тайван байдалд аюул учруулах болсон байна.

Иймээс амьтан тэжээгч нь тухайн амьтан, түүний үр удмын өмнөөс тэдгээрийн амьдралынх нь туршид эсхүл дараагийн эзэн олдтол хариуцлага хүлээх ёстой. Амьтан тэжээгч нь амьтны тав тухтай байдал, түүний зан араншинд хүлээцтэй хандаж, халдварт өвчин болон хяналтгүй үржүүлгээс сэргийлэх үүрэгтэй. Тэжээгч нь тэжээж буй амьтнаа хяналтаас гадуур тэнүүчилж, нийгэм ба хүрээлэн буй орчинд хүндрэл, аюул учруулахгүй байх боломжит бүх арга хэмжээг авах зэрэг амьтан тэжээгч /эзэмшигч/-ийн үүрэг хариуцлагыг баталгаажуулах хэрэгцээ шаардлага гарч байна.

Улаанбаатар хотод нийтийн орон сууцны гадна талбайд гэрийн тэжээвэр амьтан ялангуяа нохой салхилуулах зориулалтын газар байхгүйгээс хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гадна талын ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбай зэрэгт нохойгоо салхилуулж байна. Улаанбаатар хотын нийтийн орон сууцны ихэнх байруудад амьтан салхилуулах зориулалтын газар байхгүй, ялангуяа нохойны тав тухыг хангах, гүйж харайхад зориулсан талбай байхгүй байгаа нь амьтны эрхийг зөрчиж байна.

Зураг 4. Орон сууцны гадна орчин

Баянгол дүүрэг



Баянгол дүүрэг



Чингэлтэй дүүрэг





Сүхбаатар дүүрэг



### 3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны хамрах хүрээтэй уялдуулан суурьшлын бүс дэх тэжээвэр амьтантай холбоотой стандартын суурь судалгааг 2 төрлийн асуулгатайгаар хийхээр төлөвлөсөн бөгөөд өрхийн болон төрийн бус байгууллагын гэсэн хоёр асуулга боловсруулсан.

Судалгааны өрхийн түүвэрлэлтийг хийхдээ 2021 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар хотын өрх, хүн амын бүртгэл, нохой муур бүртгэл болон албан ёсны статистикийн мэдээнд хамрагдсан сууц өмчлөгчдийн холбоодын мэдээллийг ашигласан болно.


### 3.1 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Судалгаанд Улаанбаатар хотын байшин хороололд амьдарч буй нохой, муур тэжээдэг өрх, сууц өмчлөгчдийн холбоо (СӨХ)-дыг судалгааны нэгж гэж үзсэн.

### 3.2 СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ

Суурь судалгааны түүвэрлэлтийг хийхдээ олон шатлалт түүвэрлэлтийн аргыг санамсаргүй түүврийн аргатай хослуулан ашигласан. (Зураг 3-д) Судалгааны түүвэрлэлтийг хийхдээ өрх болон төрийн бус байгууллага гэсэн хоёр түүвэр хийсэн. Төрийн бус байгууллага буюу Сууц өмчлөгчдийн холбоодоос орон сууцны эрүүл ахуй, орчны аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл цуглуулах зорилгоор суурь судалгааны нэгж болгосон.

Зураг 5. Түүвэрлэлтийн үе шатууд



2021 оны эцсийн байдлаар Улаанбаатар хотод 9 дүүргийн 178 хороонд 412.5 мянган өрх амьдарч байна. Суурь судалгааг явуулах цаг хугацаа болон санхүүгийн хязгаарлагдмал байдалтай холбоотойгоор нийслэлийн 9 дүүргээс нийслэлд хөгжлийн индексээр тэргүүлдэг Хан-Уул дүүрэг, хамгийн олон нохой мууртай Сонгинохайрхан дүүрэг, алслагдмал дүүргийн нэг болох Багануур дүүргийг сонгосон болно.

Суурь судалгаанд сонгогдсон 3 дүүрэг нь нийт 69 хороотой ба Хан-уул дүүргийн байшин хорооллын 13 хороо, Сонгинохайрхан дүүргийн байшин хорооллын 13 хороо, Багануур дүүргийн байшин хорооллын 2 хороо нийтдээ 28 хороог судалгаанд хамруулахаар сонгосон. Эдгээр 28 хороо нь дүүрэг тус бүрийн төвийн болон захын дүүргүүдийн байшин хорооны өрхүүдийг төлөөлж байгаа болно.

Хүснэгт 3. Судалгааны хамрах хүрээ тодорхойлох тооцоо, 2021 оны жилийн эцсийн байдлаар

Дүүрэг	Хорооны тоо	Орон сууцны хорооны тоо*	Өрхийн тоо	Нохойны тоо	Муурын тоо
Багануур	5	2	8557	1171	66
Баянгол	25	18	62784	4734	169
Баянзүрх	28	18	104881	11451	349
Багахангай	2	-	1222	99	20
Сүхбаатар	20	11	39302	4763	238
Сонгинохайрхан	43	13	90231	20836	405
Чингэлтэй	19	6	38413	7371	263
Хануул	28	13	56874	4734	359
Налайх	8	-	10263	2222	112
Нийслэл	178	81	412527	55121	1981

\*- дан орон сууцны хороо

Сонгогдсон дүүргүүдийн 28 хороо нь нийт 63101 өрхтэй бөгөөд 2321 нохой, муур бүхий өрхөөс судалгааны асуулга авахаар тооцов. Суурь судалгаанд сонгогдсон өрхийн тоо нийслэлийн нийт өрхийн 3.7 хувь, судалгаанд сонгогдсон дүүргийн орон сууцанд амьдардаг өрхийн 15.8 хувь нь болж байна.

Суурь судалгаанд сонгогдсон Хан-Уул дүүрэг нь хамгийн олон орон сууцны хороололтой бөгөөд сүүлийн жилүүдэд барилгажилт огцом нэмэгдэн, тэр дундаа олон төрлийн орон сууцууд баригдаж байгаа дүүрэг юм.

Иймээс Хан-Уул дүүргийн орон сууц бүхий 13 хорооны нохой мууртай 1488 өрхийг суурь судалгаанд сонгож авсан.

Хүснэгт 4. Хан-Уул дүүргийн орон сууцны хороодын тоо, 2022.01.01-ний байдлаар

Д/д	Хорооны нэр	Нийт өрхийн тоо	Орон сууцны хороодын өрхийн тоо	Нохой муурын тоо
1	1-р хороо	2456	2452	33
2	2-р хороо	3061	3049	30
3	3-р хороо	3488	3432	45
4	4-р хороо	5018	3284	301
5	10-р хороо	2474	1301	337
6	11-р хороо	3809	3139	18
7	15-р хороо	4159	4116	77
8	16-р хороо	4054	2053	515
9	17-р хороо	3491	3201	49
10	18-р хороо	2389	2345	21
11	19-р хороо	2932	2883	28
12	20-р хороо	2676	2662	22
13	21-р хороо	2389	2252	12
Хан-Уул дүүргийн дүн		42396	36169	1488

Суурь судалгаанд Сонгинохайрхан дүүргийн орон сууц бүхий 13 хорооны 452 нохой мууртай өрх судалгаанд сонгогдсон. Сонгинохайрхан дүүрэг нь нийслэл хотод хамгийн олон нохой мууртай гэсэн боловч орон сууцанд амьдардаг нохой муурын хувьд харьцангуй цөөн байна.

Хүснэгт 5. Сонгинохайрхан дүүргийн орон сууцны хороодын тоо, 2022.01.01-ний байдлаар

Д/д	Хорооны нэр	Нийт өрхийн тоо	Орон сууцны хороодын өрхийн тоо	Нохой муурын тоо
1	12-р хороо	1206	1206	15
2	13-р хороо	1302	1302	28
3	14-р хороо	1277	1277	20
4	15-р хороо	1320	1320	35
5	16-р хороо	1539	1539	17
6	17-р хороо	1316	1316	9
7	18-р хороо	2117	2117	18
8	19-р хороо	3197	3178	24
9	20-р хороо	2049	1411	150
10	27-р хороо	2157	2060	38
11	29-р хороо	2512	2508	15
12	37-р хороо	2950	2879	61
13	38-р хороо	1408	1396	22
Сонгинохайрхан дүүргийн дүн		24350	23509	452

Нийслэлийн алслагдмал 3 дүүргийн нэг болох Багануур дүүргийн хувьд хаяа дүүргүүдээ төлөөлөх чадвартай гэж үзсэн бөгөөд орон сууцны 2 хороонд 381 нохой мууртай өрх байна.


**Хүснэгт 6. Багануур дүүргийн орон сууцны хороодын тоо, 2022.01.01-ний байдлаар**

Д/д	Хорооны нэр	Нийт өрхийн тоо	Орон сууцны хороодын өрхийн тоо	Нохой муурын тоо
1	1-р хороо	2482	1699	242
2	3-р хороо	2244	1724	139
Багануур дүүргийн дүн		4726	3423	381

Суурь судалгаанд хамрагдах төрийн бус байгууллага буюу сууц өмчлөгчдийн холбоо(СӨХ)-г сонгохдоо Нийслэлийн Статистикийн газарт албан ёсны статистикийн мэдээ тайланд хамрагддаг 142 СӨХ-дыг түүвэрлэлтийн эхний шатны нэгж болгосон.

Суурь судалгаанд Баянгол, Чингэлтэй дүүргийг сонгосон бөгөөд тус бүр 22 сууц өмчлөгчдийн холбоог сонгосон. Сонгогдсон 2 дүүргийн нийт 44 сууц өмчлөгчдийн холбоод нь албан ёсны мэдээнд хамрагддаг нийт сууц өмчлөгчдийн холбооны 30.9 хувь болж байна. СӨХ-ийг сонгохдоо санамсаргүй түүврийн аргыг ашигласан бөгөөд сонгогдсон СӨХ-үүд бусад СӨХ-үүдээ төлөөлөх чадвартай гэж үзсэн.

**Зураг 6. Албан ёсны статистикийн мэдээ өгдөг сууц өмчлөгчдийн холбоодын тоо, дүүргээр**



Судалгааны түүврийн хэмжээ ба хамрагдалтын байдлыг 2321 өрх, 44 сууц өмчлөгчдийн холбоодоос 100.0 хувь авна гэж тооцов.( Хүснэгт 7.)

**Хүснэгт 7. Судалгааны түүврийн хэмжээ, хамралт**

Дүүрэг	Судалгаанд сонгогдсон өрхийн тоо	Өрхийн хамралтын хувь	Дүүрэг	Судалгаанд сонгогдсон СӨХ-ын тоо	СӨХ-ын хамралтын хувь
Хан-Уул	1488	100	Баянгол	22	100
Багануур	381	100	Чингэлтэй	22	100
Сонгинохайрхан	452	100			
Нийт	2321	100	Нийт	44	100

### 3.3 СУУРЬ СУДАЛГААНЫ АСУУЛГА

Асуулгын хуудасны загвар боловсруулахад юуны өмнө тухайн сэдвийн хүрээнд судлагдсан байдалтай танилцсаны дараа судалгааны зорилгыг нарийвчлан тодорхойлсон.

Асуулгын хуудасны асуулт, хариулт нь энгийн ойлгомжтой үг хэллэгтэй байх, судалгаанд оролцогч бүрэн ойлгож, хариулах нөхцөлийг ханган суурь судалгаанд хоёр төрлийн асуулга бэлтгэсэн. Үүнд, судалгааны асуулгууд дараах бүтэцтэй байна.

- Өрхийн судалгааны асуулга (Хавсралт 8. Өрхийн судалгааны асуулга) нийт 3 бүлгийн 27 асуулгатай бэлтгэсэн бөгөөд гэрийн тэжээвэр амьтантай өрхүүд 1,3 бүлгийн асуулгыг, гэрийн тэжээвэр амьтангүй өрхүүд 2,3 бүлгийн асуулгыг хариулахаар хийсэн.
- Төрийн бус байгууллагын судалгааны асуулга (Хавсралт 9.Төрийн бус байгууллагын судалгаан асуулга) 4 асуулттай.

Өрхийн асуулга:

- Хаягийн хэсэг
  - Дүүрэг
  - Хороо
  - Холбоо барих утасны дугаар
  - Ярилцлага авагчийн нэр
  - Ахлагчийн нэр
- Асуулга

1.Танайх гэрийн тэжээвэр амьтантай юу?

1.1 Тийм бол ямар амьтан тэжээдэг вэ?

- Нохой
- Муур
- Загас
- Усан гахай
- Шувуу
- Яст мэлхий
- Бусад

1.2 Яагаад тэжээх болсон шалтгаан юу вэ?

- Хүүхдүүд тэжээхийг хүссэн
- Хөрөнгөө мануулах
- Ганцаараа байдаг
- Хобби
- Эрүүл мэндийн шалтгаан
- Бусад

1.3 Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд хүндрэл гардаг уу?

- Гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд чанга дуу гардаг
- Гэрийн тэжээвэр амьтан салхилуулах газар байрны орчинд байхгүй
- Хөршүүд тав тух алдаж байгаа талаар гомдоллодог
- СӨХ-ноос оршин суугчид гомдол мэдүүлдэг талаар болон нэмэгдэл төлбөр авах сануулга ирүүлдэг
- Амьтад янз бүрийн үнэр гаргадгаас болж эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн
- Тэжээвэр нохой муур хүн рүү дайрсан, хүүхэд айлгасан
- Байрны дундын болон олон нийтийн эзэмшлийн талбай бохирдуулсан
- Бусад

1.4 Танай гэрийн тэжээвэр амьтан гэрчилгээтэй юу?

1.5 Танайх гэрийн тэжээвэр амьтандаа вакцин, тарилга хийлгэдэг үү?

1.6 Та гэрийн тэжээвэр амьтнаа салхилуулахдаа ялгадсыг нь цэвэрлэдэг үү?

- Үгүй бол
  - Ялгадас хийх уутгүй
  - Ялгадсыг авах шаардлагагүй
  - Хүүхдүүд тэжээвэр амьтны салхилуулдаг
  - Гэртээ зориулалтын савтай
  - Бусад

1.7 Амьтны эмнэлэгт хир давтамжтай үзүүлдэг вэ?

- Сар тутам
- Улирал тутам
- Хагас жилд
- Жил бүр
- Зөвхөн өвдсөн үед
- Вакцины товлолт хугацаанд
- Бусад

- 1.8 Та тэжээвэр амьтныхаа ариун цэврийг хэрхэн сахиулдаг вэ?
- Хоолны сав, хэвтрийг байнга цэвэрлэж, ариутгадаг
  - Тогтмол эмнэлэгт үзүүлж, туулгад хамруулдаг
  - Байнга усанд оруулдаг
  - Тогтмол салхилуулдаг
  - Тогтмол үсийг нь самнадаг
  - Вакцин хийлгэдэг
  - Зориулалтын хоолоор тэжээдэг
  - Бусад
- 1.9 Та болон танай гэр бүлийн гишүүдээс тэжээвэр амьтнаас шалтгаалсан өвчнөөр өвдөж байсан уу?
- 1.10 Та тэжээвэр амьтандаа үржил хязгаарлах мэс засал буюу спэй хийлгэсэн үү?

Тийм

- Үржил зогсоно
- Гэрээс холдож, гадуур тэнэхгүй
- Зан ааш өөрчлөлт орохгүй
- Савны хорт хавдар тусах магадлал буурна
- Охин нохой муурын үнэрээр эрэгчин амьтан цуглахгүй
- Бусад

Үгүй

- Энэ талаар сайн мэдэхгүй
  - Шаардлагагүй гэж бодож байгаа
  - Үржүүлэх сонирхолтой
  - Зүй бус хандлага гэж боддог
  - Бусад
- 1.11 Тэжээвэр амьтныхаа аюулгүй байдлыг хэрхэн хангадаг вэ?
- Гадаа салхилуулахдаа байнга уяатай байлгадаг
  - Гадаа салхилуулахдаа байнга хошуувчтай байлгадаг
  - Гэртээ тав тухтай орчин бүрдүүлдэг
  - Тогтмол эмнэлэгт үзүүлдэг
  - Уурлуулахгүй байхыг хичээдэг
  - Гэрийн тэжээвэр амьтнаа сургадаг
  - Бусад

2. Нэгдүгээр асуултад үгүй гэж хариулсан бол

2.1 Гэртээ амьтан тэжээдэг хөршүүд тань хүндрэл бэрхшээл учруулдаг уу?

2.2 Гэртээ амьтан тэжээдэг хөршүүд тань ямар хүндрэл учруулдаг вэ?

- Гэрийн тэжээвэр амьтан янз бүрийн чанга дуу гаргаж амрахад саад болдог
- Гэрийн тэжээвэр амьтнаас муухай үнэр гардаг
- Орон сууцны дундын болон нийтийн эзэмшлийн талбай бохирдуулдаг
- Лифтэнд цуг ороход айдаг, эвгүй байдаг
- Том нохойноос айдаг, хошуувч хийдэггүй, уяа оосоргүй явдаг
- Хүн рүү дайрдаг, хүүхэд айлгадаг
- Байрны гадна талбай, ногоон байгууламж амьтны ялгадсаар дүүрсэн
- Хүүхдийн тоглоомын талбайд гэрийн тэжээвэр амьтнаа салхилуулдаг
- Бусад

3.1 Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхтэй холбоотой заавал мөрдөх аюулгүй байдлын журам,стандартын талаар мэдэх үү?

3.2 Тийм бол энэ талын мэдээллийг хаанаас авдаг вэ?

- Интернет
- Телевиз
- Сонин
- Хороо, дүүрэг, СӨХ
- Хурал, зөвлөгөөн
- Зар сурталчилгааны хуудас

- Найз, хөрш, болон бусад хүмүүсээс
- Бусад

3.3 Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд оршин суугчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор Улаанбаатар хот стандарттай байх шаардлагатай гэж бодож байна уу?

3.4 Тийм бол орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд оршин суугчдын аюулгүй байдлыг хангах хотын стандартад ямар ямар заалт оруулах хэрэгтэй вэ?

- Орон сууцны гадна орчинд амьтан салхилуулах зориулалтын газартай болох
- Амьтны ялгадас хаях зориулалтын савыг орон сууцны гадна болон гудамж талбайд байрлуулах
- Оршин суугчдад орон сууцанд амьтан тэжээх талаар заавар зөвлөмж өгөх, иргэнийг үүрэгжүүлэх
- Гэртээ амьтан тэжээдэг өрхүүд СӨХ-тэй гэрээ байгуулах, нэмэлт төлбөр, хураамж төлдөг болох
- Гэрийн тэжээвэр амьтан салхилуулахдаа хүзүүвч, хошуувч, богино уяатай байлгах, тор цүнхэнд хийх
- Оршин суугчдын тав тухыг алдагдуулахгүй байхад анхаарах, зөрчсөн тохиолдолд торгуулийн арга хэмжээ авах
- Бусад

ТББ-ын асуулга:

- Хаягийн хэсэг
  - Дүүрэг
  - Хороо
  - СӨХ-ийн нэр
  - Холбоо барих утасны дугаар
  - Судалгааны ахлагчийн нэр

1.Гэрийн тэжээвэр амьтантай өрхийн бүртгэл, мэдээлэл байдаг уу?

2.Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээж байгаа нь оршин суугчдын аюулгүй байдал болон орон сууцны гадна орчинд хүндрэл учруулж байна уу?

2.1 тийм бол ямар ямар хүндрэл бэрхшээл учруулдаг вэ?

- Оршин суугчдаас тэжээвэр амьтантай өрхийн талаар гомдол ирдэг
- Дундын болон нийтийн эзэмшлийн талбай бохирдуулдаг
- Хог хаягдал, орчны бохирдол үүсгэдэг
- Иргэдийн амьтан тэжээх талаар мэдлэг хангалтгүй
- Үйлчилгээний нэмэгдэл хөлс төлдөггүй
- Гэрийн тэжээвэр амьтан эзэмшигч нь тухайн амьтны аюулгүй байдлыг хангах талаар мэдлэг хангалтгүй байдаг
- Гэрийн тэжээвэр амьтан эзэмшигч нь оршин суугчдын тав тух, аюулгүй байдлын хангах тэд дээр анхаардаггүй
- Орон сууцны подвалд зарим амьтад үүрлэн үржсэн байдаг нь оршин суугчдын эрүүл аюулгүй амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлдэг

3.1 Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхтэй холбоотой заавал мөрдөх аюулгүй байдлын журам,стандартын талаар мэдэх үү?

3.2 Тийм бол энэ талын мэдээллийг хаанаас авдаг вэ?

- Интернэт
- Телевиз
- Сонин
- Хороо, дүүрэг, СӨХ
- Хурал, зөвлөгөөн
- Зар сурталчилгааны хуудас
- Найз, хөрш, болон бусад хүмүүсээс
- Бусад

4. Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд оршин суугчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор Улаанбаатар хот стандарттай байх шаардлагатай гэж бодож байна уу?

4.1 Тийм бол Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд оршин суугчдын аюулгүй байдлыг хангах хотын стандартад ямар ямар заалт оруулах хэрэгтэй вэ?

- Орон сууцны гадна орчинд амьтан салхилуулах зориулалтын талбайтай болох
- Амьтны ялгадас хаях зориулалтын савыг орон сууцны гадна болон гудамж талбайд байрлуулах
- Иргэдийн гэртээ амьтан тэжээх талаар мэдлэг хангалтгүй
- Орон сууцанд амьтан тэжээдэг өрхүүд нэмэлт төлбөр, хураамж төлдөг болох
- Гэрийн тэжээвэр амьтныг бүртгэлжүүлэх, эрүүл аюулгүй байдлыг хангахад эзэмшигчийн үүрэг хариуцлагыг тодорхойлох
- Орон сууцанд тэжээж байгаа гэрийн тэжээвэр амьтны эрүүл мэнд, аюулгүй байдал, тав тухыг хангах талаар заалт оруулах
- Гэрийн тэжээвэр амьтныг салхилуулах тодорхой цаг заах
- Орон сууцанд тэжээж болох болон тэжээж болохгүй амьтны жагсаалт гаргах
- Том хэмжээтэй нохой болон гаршуулсан зэрлэг амьтныг орон сууцанд тэжээхгүй байх
- Бусад

### 3.4 СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ, ШИНЖИЛГЭЭ

Асуулгын хуудсаар цуглуулсан мэдээллийн бүрэн байдал, хариултуудын уялдаа холбоог хянаж засварлах, нээлттэй асуултуудаар цуглуулагдсан мэдээллүүдийг компьютерт шивж оруулах ажлуудыг судалгааны баг гүйцэтгэсэн.

Судалгааны мэдээллийг статистик шинжилгээний Survey123 программын тусламжтайгаар компьютерт оруулан, боловсруулалт хийж, энгийн тайлбар статистикийн аргаар шинжилгээ, тайлбаруудыг хийв.

### 3.5 СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ

Энэ удаагийн судалгаа нь цаг хугацаа болон санхүүгийн хязгаарлагдмал байдалтай холбоотойгоор зөвхөн Улаанбаатар хотын зарим дүүрэг, хорооны өрх, сууц өмчлөгчдийн холбоодыг хамруулсан. Өрхийн түүвэрт 2021 оны жилийн эцсийн байдлаар нохой, муурын тоог авсан бөгөөд нэг нохой, муур нэг өрх гэж тооцсон. Магадгүй зарим өрх хоёр ба түүнээс дээш амьтантай байхыг үгүйсгэхгүй. 2022 оны тоо мэдээлэл гараагүй тул нохой мууртай өрхийн тоо өөрчлөгдөх боломжтой. Үүнээс шалтгаалан судалгаанд хамрагдах өрхийн тоо өөрчлөгдөх магадлалтай.

Мөн орон сууцны орчны эрүүл, аюулгүй байдлын талаарх СӨХ-ын байр суурь, хандлагыг нэг ажилтны үзэл бодол бүрэн төлөөлөх албагүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй ба бид асуулгад орсон асуултуудын дагуу мэдээллийг аль болох бүрэн гүйцэт авах үүднээс тухайн асуудлыг хамгийн сайн мэддэг гэж үзсэн ажилтныг СӨХ-ын судалгааны оролцогч /хариулагч/-аар сонгосон болно.




#### 4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Суурьшлын бүсэд эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх, хотын стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах зорилгоор хийгдэж байгаа энэхүү суурь судалгааны гол үзүүлэлт болох орон сууцанд амьтан тэжээдэг өрхөөс гадна тэдгээрийн хөршөөс мэдээлэл цуглуулах аргыг зөв сонгохоос хамаарч үр дүн алдаагүй, нарийвчлал сайтай байх нь шалтгаалах юм.

Үүнийг харгалзан мэдээлэл цуглуулалтын арга, хэлбэрийг сонгохдоо цаасан хэлбэрээр иргэдээс (талбарын) шууд асуулгаар авах, утсаар асуулга авч нөхөх, цахим асуулгын аргыг ашиглан мэдээлэл цуглууллаа.

Зураг 7. Мэдээлэл цуглуулсан хэлбэрүүд



**CAPI:** Компьютерт суурилсан шууд ярилцлага (Computer-Assisted Personal Interviewing),

**CATI:** Компьютерт суурилсан телефон ярилцлага (Computer-Assisted Telephone Interviewing),



**Face to face interview** буюу нүүр тулсан ярилцлага

Судалгааг Хан-Уул дүүргийн 13 хороо, Сонгинохайрхан дүүргийн 13 хороо, Багануур дүүргийн 2 хороо, нийтдээ 28 хороонд явуулсан. Мэдээлэл цуглуулахдаа цаасан хэлбэрээс гадна цахим асуулгыг зөвхөн өрхийн асуулгаар хийсэн бөгөөд орон зайн байршилд суурилсан Survey123 программыг ашигласан.

Орон зайн мэдээлэл авах боломжтой тус программ нь судалгааны асуулгыг боловсруулахад хялбар, тодорхой шалгалтын функцүүдтэй, үр дүнг хялбар байдлаар гарган авч боловсруулах боломжтой, онлайн болон офлайн горимд ажиллах давуу талтай. Энэ программыг ашигласнаар сонгогдсон 3 дүүргийн хороонд судалгаанд хамрагдаж байгаа эсэхийг тухай бүр хянах боломж бүрдсэн. (Хавсралт 10, 11, 12 Улаанбаатар хотын тэжээвэр амьтны судалгаа авсан байршил, газрын зурагт дүрсэлснээр)

Судалгааг явуулахдаа дүүргүүдийн Статистикийн хэлтсээр дамжуулан орон сууц бүхий хороодод байдаг нохой муурын бүртгэлд үндэслэн өрхийн асуулгыг хорооны зохион байгуулагч, хэсгийн ахлагч нараар дамжуулан өрхөөс цаасан болон цахим асуулгаар судалгааг авсан.

Зураг 8. Дүүргүүдийн Статистикийн хэлтэс дээр ажиллаж байгаа нь  
Сонгинохайрхан дүүрэг



Баянгол дүүрэг



Чингэлтэй дүүрэг

Хан-Уул дүүрэг




Энэхүү судалгаагаар орон сууцанд амьдардаг өрх, үйл ажиллагаа явуулж буй СӨХ-ны байгууллага болон өрхүүдийн нохой муур тэжээдэг эсэх, тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхтэй холбоотой заавал мөрдөх дүрэм, журам, стандартын талаарх мэдлэг, хандлага, оршин суугчдын аюулгүй байдлыг хангах стандарт байх шаардлагатай эсэх талаарх иргэд, сууц өмчлөгчдийн холбоодын саналыг дэлгэрэнгүйгээр авч үзсэн болно.

#### 4.1 ӨРХИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд нийт 2161 өрхийг хамруулсан бөгөөд гэрийн тэжээвэр амьтантай 609 өрх, гэрийн тэжээвэр амьтангүй 1552 өрх байна. Энэхүү хэсэгт оролцсон өрхүүдийн гэрийн тэжээвэр амьтантай эсэх, ямар амьтан тэжээдэг, тэжээх болсон шалтгаан, тэжээхэд хүндрэл гардаг эсэхийн талаар танилцуулж байна. Судалгаагаар Улаанбаатар хотоос сонгогдсон 5 дүүргийн орон сууцны хороололд амьдардаг 2161 өрхийн 28.0 хувь нь гэрийн тэжээвэр амьтан тэжээдэг байна.

Зураг 9. Гэрийн тэжээвэр амьтан тэжээдэг болон тэжээдэггүй өрхийн тоо



Гэртээ амьтан тэжээдэггүй 1552 өрх байгаагаас амьтан тэжээдэг хөршүүд нь хүндрэл учруулдаггүй гэж 75.0 хувь нь хариулсан байна.

Хүснэгт 8. Гэртээ амьтан тэжээдэг хөршүүдийн учруулдаг хүндрэл, эрэмбэлсэн байдлаар, хувиар

Эрэмбэ	Заалтын дугаар								Тоо	Хувь
	1	2	3	4	5	6	7	8		
I	1	2	3	4	5	6	7	8	109	27.6%
II	3	1	2	4	5	6	7	8	41	10.4%
III	4	1	2	3	5	6	7	8	25	6.3%
IV	2	1	3	4	5	6	7	8	20	5.1%
V	7	1	2	3	4	5	6	8	19	4.8%
VI	5	1	2	3	4	6	7	8	11	2.8%
VII	6	1	2	3	4	5	7	8	9	2.3%
VIII	8	1	2	3	4	5	6	7	9	2.3%
IX	6	3	7	2	5	8	1	4	7	1.8%
X	5	4	3	6	7	1	2	8	5	1.3%
XI	7	8	1	2	3	4	5	6	4	1.0%
XII	1	3	6	8	2	4	5	7	136	34.3%
Нийт									395	100%

Заалтын дугаарын хариулт

- 1 Гэртээ тэжээдэг амьтан нь янз бүрийн чанга дуу гаргаж амрахад саад болдог
- 2 Гэрийн тэжээвэр амьтнаас муухай үнэр гардаг
- 3 Орон сууцны дундын болон нийтийн эзэмшлийн бохирдуулдаг
- 4 Лифтэнд нохойтой цуг орохдоо айдаг, эвгүй байдаг
- 5 Том нохойноос айдаг, хошуувч хийдэггүй, уяа оосоргүй явдаг
- 6 Хүн рүү дайрдаг, хүүхэд айлгадаг
- 7 Байрны гадна талбай, ногоон байгууламж амьтны ялгадсаар дүүрсэн
- 8 Хүүхдийн тоглоомын талбайд гэрийн тэжээвэр амьтнаа салхилуулдаг  
Бусад /бичих/

Гэрийн тэжээвэр амьтантай хөршүүд нь хүндрэл учруулдаг гэж 395 өрх буюу 25.0 хувь нь хариулсан байна. Эдгээр хүндрэл бэрхшээлийг (Хүснэгт 8.) хамгийн чухлаар нь эрэмбэлж үзэхэд, "гэрийн тэжээвэр амьтан нь янз бүрийн чанга дуу гаргаж амрахад саад болдог" гэж дийлэнх нь хариулжээ.

Судалгаанаас харахад нохойтой өрх 70.0 хувь, мууртай өрх 23.0 хувь, 2 ба түүнээс дээш гэрийн тэжээвэр амьтантай (нохой, муур) өрх 2.0 хувь, бусад амьтантай өрх 5.0 хувийг эзэлж байна.

Уг судалгаанд оролцсон өрхүүд амьтан тэжээх болсон шалтгаанаа нэрлэснийг авч үзвэл, 324 буюу 53.2 хувь нь хүүхдүүд тэжээхийг хүссэн, 212 буюу 34.8 хувь нь хобби гэх зэргээр хариулсан байна.

Хүснэгт 9. Гэрийн тэжээвэр амьтан тэжээх болсон шалтгаан, төрлөөр, хувиар

Тэжээдэг амьтны төрөл	Гэртээ амьтан тэжээх болсон шалтгаан						
	Хүүхдүүд тэжээхийг хүссэн	Хөрөнгөө мануулах	Ганцаараа байдаг	Хобби	Эрүүл мэндийн шалтгаан	Бусад	Нийт
Нохой	217	14	24	156	4	9	424
Муур	86		8	37	2	4	137
Загас	9		1	9			19
Нохой, Муур	5	1	1	3	1	2	13
Нохой, Загас				2			2
Гоёлын шувуу				2			2
Яст мэлхий	6			2	1		9
Загас, Яст мэлхий				1			1
Муур, Усан_гахай	1						1
Бусад						1	1
Нийт	324	15	34	212	8	16	609

Амьтан тэжээдэг иргэдээс амьтан тэжээхэд хүндрэл гардаг эсэхийг тодруулахад 33.2 хувь нь хүндрэлгүй, 32.7 хувь нь гэрийн тэжээвэр амьтан салхилуулах газар байрны гадна орчинд байхгүй гэх шалтгаанууд дийлэнх хувийг эзэлж байна.

Зураг 10. Гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд гарч байгаа хүндрэл, хувиар




Судалгаанд оролцогчдын 450 буюу 74.0 хувь нь тэжээвэр амьтны гэрчилгээтэй гэж хариулсан бөгөөд ихэнх амьтан тэжээдэг иргэд зохих ёсны журмаа мөрдөн амьтандаа гэрчилгээг нь авч хороондоо бүртгүүлсэн байна.

Хүснэгт 10. Гэрийн тэжээвэр амьтны гэрчилгээ авсан болон вакцин, тарилга хийлгэсэн байдал, төрлөөр

Тэжээдэг амьтны төрөл	1.4 Танай гэрийн тэжээвэр амьтан гэрчилгээтэй юу?		Танайх гэрийн тэжээвэр амьтандаа вакцин, тарилга хийлгэдэг үү?	
	1. Тийм	2. Үгүй	1. Тийм	2. Үгүй
Гоёлын шувуу		2		2
Загас	1	18	1	18
Загас, Яст мэлхий		1		1
Муур	76	61	106	31
Муур, Усан гахай		1	1	
Нохой	363	61	383	41
Нохой, Загас	1	1	2	
Нохой, Муур	8	5	9	4
Яст мэлхий		9	2	7
Бусад	1			1
Нийт	450	159	504	105

Дээрх хүснэгтээс харахад тэжээвэр амьтантай өрхүүдийн 83.0 орчим хувь нь тэжээдэг амьтандаа вакцин тарилгаа хийлгүүлдэг байна.

Зураг 11.Тэжээвэр амьтнаа салхилуулахдаа ялгадсаа цэвэрлэдэг эсэх, шалтгаанаар, хувиар



Судалгаанд хамрагдсан өрхийн 77.0 хувь нь гэрийн тэжээвэр амьтнаа салхилуулахдаа ялгадсаа цэвэрлэдэг бол 23.0 хувь нь ялгадсаа цэвэрлэдэггүй гэж хариулсан байна. Шалтгааныг тодруулахад 48 хувь нь гэртээ зориулалтын савтай гэж тайлбарласан байна.

Амьтнаа эмнэлэгт хэр давтамжтай үзүүлдэг талаарх хариултыг дүүргээр авч үзэхэд Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн ихэнх хувь нь вакцины товлолц хугацаанд эмнэлэгт үзүүлдэг гэж хариулсан байна. Харин Багануур дүүргийн гэрийн тэжээвэр амьтантай өрхүүд улирал тутам, хагас жил тутамд эмнэлэгт очдог гэж 23.0-27.0 орчим хувь нь хариулсан байна.

Хүснэгт 11. Гэрийн тэжээвэр амьтнаа эмнэлэгт үзүүлсэн байдал, дүүргээр, хувиар

Дүүрэг	Бусад	Вакцины товлолт хугацаанд	Жил бүр	Зөвхөн өвдсөн үед	Сар тутам	Улирал тутам	Хагас жилд	Нийт
Багануур	15.5	11.5	3.8	11.5	7.7	26.9	23.1	100
Сонгино хайрхан	1.7	30.8	5.6	27.5	6.4	18.9	9.1	100
Хан-Уул	6.9	28.6	11.7	10.3	10.1	24.3	8.1	100

Амьтнаа эмнэлэгт хэр давтамжтай үзүүлдгийг амьтны нэр төрлөөр авч үзэхэд нохой, муураа вакцины товллолт хугацаанд эмнэлэгт үзүүлдэг гэж 29.0 хувь нь хариулсан нь судалгаанд ихэвчлэн нохой муур тэжээдэг иргэд хамрагдсантай холбоотой байхыг үгүйсгэх аргагүй юм.

Хүснэгт 12. Гэрийн тэжээвэр амьтнаа эмнэлэгт үзүүлсэн байдал, амьтны төрлөөр, давтамжаар

Тэжээдэг амьтны төрөл	Амьтны эмнэлэгт хэр давтамжтай үзүүлдэг вэ?							
	Бусад	Вакцины товллолт хугацаанд	Жил бүр	Зөвхөн өвдсөн үед	Сар тутам	Улирал тутам	Хагас жилд	Нийт
Гоёлын шувуу	1			1				2
Загас	15	1		2	1			19
Загас, Яст				1				1
Муур	7	37	17	31	9	28	8	137
Муур,			1					1
Нохой	6	131	35	64	39	105	44	424
Нохой, Загас					2			2
Нохой, Муур		7	1	2		1	2	13
Яст мэлхий	3		1	1	1	2	1	9
Бусад				1				1
Нийт	32	176	55	103	52	136	55	609

Судалгаанд хамрагдсан өрхүүд гэрийн тэжээвэр амьтнаа байнга усанд оруулдаг, хоолны сав, хэвтрийг нь байнга цэвэрлэж ариутгадаг, тогтмол салхилуулдаг, вакцин хийлгэдэг гэх зэргээр ариун цэврийг нь сахиулдаг байна.

Хүснэгт 13. Гэрийн тэжээвэр амьтныхаа ариун цэврийг сахиулдаг байдал, давтамжаар, хувиар


Та тэжээвэр амьтныхаа ариун цэврийг хэрхэн сахиулдаг вэ?	Давтамж	Хувь
Хоолны сав, хэвтэрийг байнга цэвэрлэж, ариутгадаг	268	44.0
Тогтмол эмнэлэгт үзүүлж, туулгад хамруулдаг	151	24.8
Байнга усанд оруулдаг	272	44.6
Тогтмол салхилуулдаг	215	35.3
Тогтмол үсийг нь самнадаг	126	20.7
Вакцин хийлгэдэг	212	34.8
Зориулалтын хоолоор тэжээдэг	194	31.8
Бусад	161	26.4

Та болон танай гэр бүлийн гишүүдээс тэжээвэр амьтнаас шалтгаалсан өвчнөөр өвдөж байсан эсэхийг лавлахад, 19 буюу 3 хувь (нохой, муураас шалтгаалсан) нь тийм, 590 буюу 97.0 хувь нь үгүй гэж хариулжээ.

Тэжээвэр амьтандаа үржил хязгаарлах мэс засал буюу спэй хийлгэсэн эсэхийг асуухад судалгаанд оролцсон амьтантай нийт өрхийн 68.8 хувь нь амьтандаа үржил хязгаарлах спэй хийлгэсэн гэж хариулсан байна. Тэжээвэр амьтандаа спэй хийлгэсэн шалтгааныг тодруулахад дийлэнх буюу 62.1 хувь нь үржил зогсоно, 14.7 хувь нь гэрээсээ холдож, гадуур тэнэхгүй 10.0 хувь нь охин нохой, муурын үнэрээр эрэгчин амьтад цуглахгүй, 3.7 хувь нь савны хорт хавдар тусах магадлал буурна, 2.1 хувь нь бусад шалтгааныг сонгож хариулсан байна.

Харин тэжээвэр амьтандаа спэй хийлгээгүй өрхүүдийн 54.0 хувь нь үржил хязгаарлах мэс засал буюу спэй хийлгэх шаардлагагүй гэж үзсэн байна.

Зураг 12. Үржил хязгаарлах мэс засал буюу спэй хийлгээгүй шалтгаан, хувиар



Тэжээвэр амьтан тэжээхтэй холбоотой журам, стандартын талаарх иргэдийн мэдлэг, хандлага

Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхтэй холбоотой заавал мөрдөх аюулгүй байдлын журам, стандартын талаар мэддэг эсэхийг асуухад 697 буюу 68.0 хувь нь энэ талаар ойлголт, мэдлэгтэй гэж хариулжээ.

Хүснэгт 14. Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхтэй холбоотой заавал мөрдөх аюулгүй байдлын журам, стандартыг талаарх иргэдийн мэдлэгийн байдал

Хариултын төрөл	Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхтэй холбоотой заавал мөрдөх аюулгүй байдлын журам, стандартын талаар мэдэх үү?		
	Тийм	Үгүй	Нийт
Танайх гэрийн тэжээвэр амьтантай юу?			
Тийм	382	227	609
Үгүй	315	1237	1552
Нийт	697	1464	2161

Гэрийн тэжээвэр амьтан тэжээхтэй холбоотой заавал мөрдөх аюулгүй байдлын журам, стандартын талаар ойлголттой гэж хариулсан өрхүүд ихэвчлэн энэ талаарх мэдээллээ интернэт буюу веб хуудаснаас авдаг (79.1%) гэдгийг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт 15. Заавал мөрдөх аюулгүй байдлын журам, стандартын талаарх мэдээллийг авсан эх сурвалж, хувиар

Мэдээллийн суваг	Давтамж	Хувь
Интернет/вэб хуудас/	430	79.1
Телевиз	155	28.5
Зар сурталчилгааны хуудас	21	3.9
Найз, хөрш болон бусад хүмүүсээс	92	16.9
Бусад /зориулалтын газар, сургалтын байгууллага, сэтгүүлээс мэдээлэл авсан/	3	0.5

Судалгаанд оролцсон нийт өрхүүдийн хувьд орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд оршин суугчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор Улаанбаатар хот стандарттай байх шаардлагатай гэж 1588 өрх буюу 73.5 хувь үзсэн байна. Шаардлагагүй гэж үзсэн нь 26.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт 16. Гэрийн тэжээвэр амьтантай болон амьтангүй хүмүүсийн стандартын талаарх санал бодол

хариултын төрөл	Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд оршин суугчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор Улаанбаатар хот Стандарттай байх шаардлагатай гэж бодож байна уу?		
Танайх гэрийн тэжээвэр амьтантай юу?	Тийм	Үгүй	Нийт
Тийм	510	99	609
Үгүй	1078	474	1552
Нийт	1588	573	2161

Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээх, оршин суугчдын аюулгүй байдлыг хангах хотын стандарт шаардлагатай гэж үзсэн 1588 өрхүүдийн хувьд орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд нэмэлт хураамжтай болох, орон сууцны гадна талд гэрийн тэжээвэр амьтан салхилуулах зориулалтын талбайтай болох, иргэдэд гэртээ амьтан тэжээх талаар мэдлэгийг олгох, дээшлүүлэх гэх зэрэг заалтуудад голлон саналуудыг өгсөн байна.

Хүснэгт 17. Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээх, оршин суугчдын аюулгүй байдлыг хангах хотын стандартын заалтад оруулах санал, давтамжаар, хувиар

№	Тийм бол хотын стандартад ямар ямар заалт оруулах хэрэгтэй вэ?	Давтамж	Хувь
1	Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд нэмэлт төлбөр хураамжтай болох	870	54.7
2	Орон сууцны гадна тал гэрийн тэжээвэр амьтан салхилуулах зориулалтын талбайтай болох	648	40.8
3	Том хэмжээтэй нохой болон гаршуулсан зэрлэг амьтан орон сууцанд тэжээхгүй байх	479	30.7
4	Иргэд гэртээ амьтан тэжээх талаар мэдлэг хангалтгүй	502	32.4
5	Орон сууцанд тэжээж байгаа гэрийн тэжээвэр амьтны эрүүл мэнд, аюулгүй байдал, тав тухыг хангах талаар заалт оруулах	388	24.4
6	Бусад/салхилах талбайтай болгох, амьтныг хамгаалах, маш сайн стандарттай болох г.м/	544	34.2



#### 4.2 СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Сууц өмчлөгчдийн холбоодоос авсан судалгаанд Баянгол, Чингэлтэй дүүргийн 80 сууц өмчлөгчдийн холбоо (СӨХ) хамрагдаж, 4 бүлгийн 7 асуултын үр дүнг тооцож гаргав. Судалгаанд хамрагдсан сууц өмчлөгчдийн холбоо (СӨХ) -ны 34 нь буюу 42.5 хувь нь амьтан тэжээдэг өрхийн бүртгэлтэй гэж хариулжээ.

Хүснэгт 18. Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээж байгаа нь оршин суугчдын аюулгүй байдал, орон сууцны гадна орчинд учруулж байгаа хүндрэл, шалтгаанаар

Шалтгааны төрөл	хариулт сонгосон тоо	хувь
Дундын болон нийтийн эзэмшлийн талбай бохирдуулдаг	54	17.6
Хог хаягдал, орчны бохирдол үүсгэдэг	52	17.3
Оршин суугчдаас тэжээвэр амьтантай өрхийн талаар гомдол ирдэг	45	15.0
Үйлчилгээний нэмэгдэл төлбөр төлдөггүй	34	11.3
Иргэдийн амьтан тэжээх талаар мэдлэг хангалтгүй	33	11.0
Гэрийн амьтан эзэмшигч нь оршин суугчдын тав тух, аюулгүй байдлыг хангах тал дээр анхаардаггүй	31	10.3
Гэрийн тэжээвэр амьтан эзэмшигч нь тухайн амьтны аюулгүй байдлыг хангах талаар мэдлэг хангалтгүй байдаг	27	9.0
Орон сууцны подвалд зарим амьтад үүрлэн, үржсэн байдаг нь оршин суугчдын эрүүл аюулгүй амьдрах орчинд сөрөг нөлөө	23	7.6
Бусад / бичих /	3	1.0

Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээж байгаа нь оршин суугчдын аюулгүй байдал болон орон сууцны гадна орчинд хүндрэл учруулж байгаа эсэх талаар асуухад нийт асуулгад оролцсон сууц өмчлөгчдийн холбооны 57 нь буюу 71.3 хувь нь тийм буюу хүндрэл учруулж байна гэсэн хариулт өгсөн байна.

- Тэжээвэр амьтан тэжээхтэй холбоотой журам, стандартын талаарх мэдлэг, хандлага

Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхтэй холбоотой заавал мөрдөх аюулгүй байдлын журам, стандартын талаар тодорхой ойлголт, мэдээлэлтэй гэж нийт судалгаанд оролцсон сууц өмчлөгчдийн холбооны 32.5 хувь нь хариулжээ.

Мэдээлэл авсан байдлыг мэдээллийн эх сурвалжаар авч үзвэл:

- интернэтээс 22 буюу 27.5 хувь,
- телевизээс 9 буюу 11.3 хувь,
- сонин, зар сурталчилгаа, найз хөршүүдээс тус бүр 5 буюу 6.3 хувь,
- хороо дүүрэг, СӨХ-оос 9 буюу 11.4 хувь,
- хурал зөвлөгөөнөөс 6 буюу 7.5 хувь нь тус тус мэдээлэл авсан байна.

Хүснэгт 19. Хотын стандартад оруулах зарим заалт, эрэмбэлснээр

№	Асуулт	Эрэмбэ									
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X
1	Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд нэмэлт төлбөр хураамжтай болох	37	8	4	6	5	5	2	1		
2	Орон сууцны гадна талд гэрийн тэжээвэр амьтан салхилуулах зориулалтын талбайтай болох	8	19	6	5	5	7	11	1	6	
3	Том хэмжээтэй нохой болон гаршуулсан зэрлэг амьтан орон сууцанд тэжээхгүй байх,	4	9	11	10	8	3	8	10	5	
4	Иргэд гэртээ амьтан тэжээх талаар мэдлэг хангалтгүй	1	7	17	11	8	10	3	6	5	
5	Гэрийн тэжээвэр амьтныг бүртгэлжүүлэх, эрүүл аюулгүй байдлыг хангахад эзэмшигчийн үүрэг хариуцлагыг тодорхойлох	6	10	3	10	17	10	8	3	1	
6	Амьтны ялгадас хаях зориулалтын савыг орон сууцны гадна болон гудамж талбайд байрлуулах	2	5	5	2	3	15	9	14	12	1
7	Гэрийн тэжээвэр амьтан салхилуулах тодорхой цаг заах	3	4	4	7	4	6	9	16	15	
8	Орон сууцанд тэжээж болох болон тэжээж болохгүй амьтны жагсаалт гаргах	4	4	5	5	3	6	4	15	22	
9	Орон сууцанд тэжээж байгаа гэрийн тэжээвэр амьтны эрүүл мэнд, аюулгүй байдал тав тухыг хангах	3	2	12	13	14	6	13	3	2	
10	Бусад							1			5

Судалгаанд оролцсон 68 сууц өмчлөгчдийн холбоод буюу 86.0 хувь нь орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээх, оршин суугчдын аюулгүй байдлыг хангах, [хотын стандарт шаардлагатай](#) гэж хариулсан байна. Эдгээр сууц өмчлөгчдийн холбоодоос шалтгааныг тодруулан хүснэгт 19-д эрэмбэлэн харуулав.

Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд нэмэлт төлбөр хураамжтай болгох гэсэн заалтыг 37 сууц өмчлөгчдийн холбоо буюу 54.4 хувь нь хотын стандартад оруулах саналтай байгаагаа илэрхийлсэн байна (Хүснэгт 19). Энэхүү асуулга нь СӨХ-ноос авсан асуулга учир тэдний ажил, үйлчилгээтэй холбоотойгоор хариулсан байх магадлалтай юм.

Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээх, оршин суугчдын аюулгүй байдлыг хангах хотын стандартад оруулах заалтад өгсөн саналыг чухлаар нь 1-10 хүртэл эрэмбэлбэл:

1. Орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд нэмэлт төлбөр хураамжтай болох
2. Орон сууцны гадна талд гэрийн тэжээвэр амьтан салхилуулах зориулалтын талбайтай болох
3. Иргэд гэртээ амьтан тэжээх талаар мэдлэг хангалтгүй
4. Орон сууцанд тэжээж байгаа гэрийн тэжээвэр амьтны эрүүл мэнд, аюулгүй байдал тав тухыг хангах талаар заалт оруулах
5. Гэрийн тэжээвэр амьтныг бүртгэлжүүлэх, эрүүл аюулгүй байдлыг хангахад эзэмшигчийн үүрэг хариуцлагыг тодорхойлох

6. Амьтны ялгадас хаях зориулалтын савыг орон сууцны гадна болон гудамж талбайд байрлуулах
7. Орон сууцанд тэжээж байгаа гэрийн тэжээвэр амьтны эрүүл мэнд, аюулгүй байдал тав тухыг хангах талаар заалт оруулах
8. Гэрийн тэжээвэр амьтан салхилуулах тодорхой цаг заах
9. Орон сууцанд тэжээж болох болон тэжээж болохгүй амьтны жагсаалт гаргах
10. Бусад буюу эзэн нь цэвэрлэх, СӨХ-дын хуульд өөрчлөлт оруулах гэсэн заалтуудад хамгийн их санал өгсөн байна.

### 4.3 ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Дэлхийн хүн амын 57 хувь нь гэрийн тэжээвэр амьтан тэжээн, гэр бүлийнхээ гишүүн болгон хайрлаж байна. Үүнээс, 33 хувь нь нохой, 23 хувь нь муур, 12 хувь нь загас, 6 хувь нь шувуу тэжээдэг байна.

АНУ-ын Gallup судалгааны байгууллагаас хийсэн тайланд хүн төрөлхтний сэтгэл зүйн тогтвортой байдал сүүлийн жилд хамгийн сөрөг буюу стресс, бухимдал ихтэй байгааг дурдсан байдаг. Дэлхийн 146 орны иргэдийн сэтгэл зүйн байдлыг өнгөрсөн 10 жилийн өмнөхтэй харьцуулсан уг судалгаанаас үзэхэд дэлхий дахинд сөрөг сэтгэл хөдлөлийн индекс нэмэгдэхийн хэрээр тэжээвэр амьтдын эрэлт хэрэгцээ улам ихсэх болжээ.

Тэжээвэр амьтдын ач тусыг ойлгосон Солонгос, Япон улс ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд ажлын байранд муур, нохой зэрэг тэжээвэр амьтдыг тэжээж эхлээд байна. Амьтан тэжээнэ гэдэг наад зах нь хөдөлгөөний идэвхтэй байхыг шаарддаг тул тэдэнтэй харилцах, хайрлах нь хүмүүст эергээр нөлөөлж бусадтай харьцах харилцаа холбоог сайжруулдаг билээ.

“Grand view” судалгааны байгууллагаас олон улсад тэжээвэр амьтны зах зээл 2025 он гэхэд 202.6 тэрбум ам.долларт хүрэх тооцоог гаргасан. Учир нь 2009 оны байдлаар дэлхий дахинд 500 сая гаруй тэжээвэр нохой байсан бол түүнээс 10 жилийн дараа буюу өнөөдрийн байдлаар 900 сая гаруй гэрийн тэжээвэр нохой амьдарч байна. Тэдэнд зориулсан эмнэлэг, дэлгүүрээс гадна алжаал тайлах, усанд оруулах спа, гоо сайхны салонууд, өдөр өнжүүлэх, сургалтын хөгжлийн төв зэрэг хүнээс дутахааргүй тансаг зэрэглэлийн олон төрлийн үйлчилгээг авах боломжтой болжээ. Ухаалаг технологи, эмнэлгийн сайн үйлчилгээ нь тэжээвэр амьтдыг илүү урт насалж, хүн шиг тав тухай амьдрах боломжийг олгож байгааг “Michelson Found Animals” байгууллагын тайлангаас уншиж болно. Тус байгууллага 1000 гаруй амьтан тэжээдэг хүмүүсээс судалгаа авахад 56 хувь нь зөвхөн амьтанд зориулан хяналтын камер, ухаалаг тоглоом, амин үзүүлэлтүүдийг хянах тусгай тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Ийнхүү тэжээвэр амьтад хүнээс дутахааргүй амьдрах орчин, хоол тэжээл, хайр халамжийг хүртэж, тэдэнд зориулсан зах зээл, бизнес, хууль эрх зүйн таатай орчин бүрдсээр байна. Иймд амьтан тэжээх олон улсын чиг хандлагын дагуу хүн амьтны хоорондын харилцааг аюулгүй зохицуулах эрх зүйн баримт бичиг зайлшгүй хэрэгтэй байна.

Дэлхийн улс орнуудын жишгээр амьтан эзэмшигч, золбин амьтныг хянах, түүнчлэн золбин амьтныг устгахтай холбоотой зохицуулалтыг өөрийн чиг үүрэг эрх мэдлийн хүрээнд боловсруулж хэрэгжүүлэх үүргийн орон нутгийн төрийн байгууллага хүлээдэг байна. Мөн амьтан эзэмшигчийн боловсрол тэдний хүлээх хариуцлагыг дээшлүүлэх явдал нь нохойд уруулах, хазуулах, тохиолдлыг бууруулах хамгийн үр дүнтэй арга юм. Нохойд уруулах хазуулах хамгийн эрсдэлтэй нийгмийн бүлэг бол бага насны хүүхэд байдаг. Нохойд уруулах хазуулах явдлыг бууруулахын тулд нохойд хамаарах зохистой зан үйлд чиглэсэн олон нийтийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэхийг дэмжих хэрэгтэй гэж үздэг байна.

Түүнчлэн дэлхийн улс орнууд гэрийн тэжээвэр амьтантай холбоотой асуудлуудын стандартыг батлан хэрэгжүүлж байна. Үүнд :

1. Эзэнтэй ба золбин нохойн эрүүл мэнд, тавлаг байдлыг сайжруулах;
2. Золбин нохойн тоог зохистой түвшинд хүргэж цөөлөх;

3. Нохойн эзний хариуцлагыг дээшлүүлэх;
4. Галзуугийн эсрэг дархлаатай, галзуу өвчнөөс ангид нохойн популяцийг бий болгох, энэ статусыг хадгалахад туслах;
5. Галзуу өвчнөөс бусад зооноз өвчний эрсдэлийг бууруулах;
6. Хүний эрүүл мэндэд учирч болох бусад эрсдэлийг (жишээ нь шимэгч хорхой) удирдах;
7. Байгаль орчин болон бусад амьтанд хор хөнөөл учруулахаас урьдчилан сэргийлэх;
8. Хууль бус худалдаа, наймаанаас сэргийлэх зэрэг ихээхэн ач холбогдолтой асуудлууд тусгасан байна.

Суурин соёл иргэншилтэй орнууд ХБНГУ, Ирланд улс, БНСУ, Оросын холбооны улс (ОХУ), БНХАУ, Австрали улсууд нь гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн зохицуулалттай бөгөөд амьтны тухай хуулийг үндэслэн хот, мужууд өөрсдийн дүрэм, журмыг орон нутгийн түвшинд нийцүүлэн, хэрэгжүүлж ирсэн байна. ХБНГУ, Ирланд улс, Австрали улсууд нийтийн орон сууцанд амьтан тэжээж болох орон сууцны ангилалтай бөгөөд зөвшөөрөгдсөн орон сууцанд ч орон сууцны зөвлөлтэй түрээсийн гэрээ байгуулан зөвшөөрөл авч тэжээдэг байна. Мөн эдгээр улсуудад нийтийн зориулалттай орон сууцанд тэжээх болохгүй амьтны жагсаалтыг гарган баталсан байдаг.


Дэлхийн улс орнуудад сүүлийн жилүүдэд нийтийн орон сууцанд амьтан тэжээх нь багасаж байгаа нь тэжээж байгаа амьтны тав тух, эрх ашгийг хамгаалах болон оршин суугчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор хотын захад эсвэл хувийн орон сууцны хороололд шилжин амьдрах нь нэмэгдэж байна гэсэн судалгаа гаргасан байна.

Хүснэгт 20. Гадаадын зарим орнуудын нохой муурын тоо, 2016 он, сая

Үзүүлэлт	БНХАУ	БНСУ*2019	ХБНГУ	ОХУ	Ирланд	Австрали
Нохой	27.4	6	5.3	12.5	0.4	3.7
Муур	53.1	2.6	8.2	17.8	0.3	2.2

Оросын холбооны улс нь орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхийг хориглоогүй боловч орон сууцанд тэжээж болох амьтны жагсаалт гаргасан байдаг байна. Австрали улс нь хөдөө аж ахуйн мал амьтанд зориулсан олон стандарт хэрэгжүүлдэг боловч гэрийн тэжээвэр амьтад буюу нийтийн орон сууцанд тэжээх амьтдын хувьд түрээсийн гэрээгээр зохицуулдаг байна.

Зураг 13. Гадаадын зарим орнуудын загас, гоёлын шувууны тоо, сая



## ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

2019 оны байдлаар ОХУ нь 33.7 сая муур, 18.9 сая нохойтой. Нохойны 54 хувь, муурын 41 хувь нь тосгонд амьдардаг байна. Оросын холбооны улсад гэрийн тэжээвэр амьтантай холбоотой асуудлыг Амьтны тухай хууль, Мал эмнэлгийн шинжлэх ухааны тухай хууль, Амьтанд туршилт хийх журам, Амьтантай харилцах дүрэм зэрэг холбооны хуулиар зохицуулдаг. 2021 онд гэрийн тэжээвэр амьтдын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд Амьтны тухай холбооны хуульд гэрийн тэжээвэр амьтдыг эмчлэх дүрэм, түүний зан үйлийн хэм хэмжээ, нохойны үүдрээс хамааран эзэмшигчийн үүрэг, эрхийг багтаасан болно.

Үүний зэрэгцээ аюултай байж болзошгүй нохойг эзэмших онцлог шинж чанаруудыг тусгасан байна. Орон сууцанд тэжээвэр амьтан байлгахыг хуулиар хориглоогүй. Гэхдээ үүнтэй зэрэгцэн орон сууцны барилгад амьдардаг бусад хүмүүсийн эрх, ашиг сонирхлыг зөрчихгүйн тулд эзэмшигчид тодорхой шаардлагыг дагаж мөрдөх ёстой. Орон сууцанд амьтдыг байлгах журамд (Хавсралт 13) орон сууцанд тэжээж болох нохой, муураас гадна зөвшөөрөгдсөн ангилалд мөн тоть, тагтаа, жижиг яст мэлхий, мэрэгч амьтад, гвинейн гахай, шижүүхэй, гоёл чимэглэлийн харх, аквариумын загас, хоргүй хоёр нутагтан, нялцгай биет, хэвлээр явагчид үржүүлэхийг зөвшөөрсөн байдаг.

Мөн гэртээ байлгахыг хориглосон амьтдын жагсаалтад матар, бар, чоно болон бусад махчин амьтад, хилэнцэт хорхой, зарим төрлийн могой, сармагчнууд багтсан болно. Орон сууцанд байлгах амьтныг төрлөөр тодорхойлогддог, учир нь тэдгээр нь тус бүр өөрийн гэсэн онцлогтой бөгөөд арчилгааны тодорхой дүрмийг дагаж мөрдөхийг шаарддаг. Нэг чухал зүйл бол амьтны амьдрах орон зайг зориулалтын дагуу ашиглах бөгөөд бусад хүмүүсийн амьдралын чанарыг дордуулахгүй байх явдал юм.

Мэдээллийн эх сурвалж: [www.spxk.ru](http://www.spxk.ru)

## ХЯТАД УЛС

2021 оны байдлаар Хятадын хот суурин газрын өрхүүдэд муур, нохойн тоо 112 сая байгаагийн 54.3 сая нохой, 58.1 сая муур байна.

Бээжин хотын Төлөөлөгчдийн хурлаар "Бээжин хотын нохой тэжээх ажлыг зохицуулах журам"- (Хавсралт 15)-ыг баталсан. Өндөр барилгууд нэмэгдэж байгаатай холбогдуулан "Хэрэв та нохойг лифтэнд авч явбал, нохойнхоо амыг таглах, нохойны уутанд эсвэл нохойны торонд хийж явах"-ыг заасан байна. Мөн нохой нь бусдын хэвийн амьдралд саад учруулахгүй байх ёстой, хуцах нь бусад хүмүүст нөлөөлж байвал нохойны эзэн түүнийг зогсоох үр дүнтэй арга хэмжээ авах хэрэгтэй.

"Бээжин хотын нохой тэжээх журам"-д нохой тэжээх, нохой тэжээх үйл ажиллагааны цар хүрээг тодорхой зааж өгсөн бөгөөд засаг захиргааны нутаг дэвсгэр дэх эмнэлэг, сургуулийн сургалтын талбай, оюутны дотуур байрны бүсэд нохой тэжээхийг хориглоно. Нохой тэжээгч хувь хүн "Хууль ёсны үнэмлэхтэй байх, иргэний зан үйлийн бүрэн чадамжтай байх, тогтмол оршин суух газартай, нэг гэр бүлд амьдардаг, байршин суух газар нь нохой тэжээдэг газраас гадуур байх ёстой" гэж журамд заасан байдаг. Иргэдийн өөрөө удирдах ёсны байгууллага нохой тэжээх, нохой тэжээхийг хориглосон газрыг зааглахаас гадна хууль ёсны нохой тэжээх мэргэшлийг авах бол оршин суугчдын хороо, тосгоны хорооноос зөвшөөрөл авах ёстой.

Зураг 14. Нохойны ялгадасны сав, БНХАУ, Бээжин хот



Мэдээллийн эх үүсвэр: <https://baike.baidu.com/item/北京市养犬管理规定/9219674>

## АВСТРАЛИ УЛС

2016 оны байдлаар Австрали улсад 29.0 сая гэрийн тэжээвэр амьтан байгаагаас 5.1 сая нохой, 3.8 сая муур, 11.3 сая загас, 5.6 сая шувуу байна. Австрали улс нь Амьтны тухай хуультай бөгөөд Малын менежментийн тухай хууль, Амьтанд харгис хэрцгий хандахаас урьдчилан сэргийлэх тухай хууль, Малын өвчлөлийн хяналтын тухай хууль зэрэг олон хуулиуд үйлчилдэг байна. Эдгээр хуулиуд нь хүний эрх мэдэл, хүн амьтдын хоорондын харилцаа, хүний үйл ажиллагаа, өмч хөрөнгө, гэмт хэрэг, зөрчлийн, захиргааны эрх зүй зэрэг харилцааг хамаардаг.

Австралийн судалгааны төвөөс хийсэн судалгааны дүнгээр Гэрийн тэжээвэр амьтдыг өмчлөгчдөд "гэрийн тэжээвэр амьтан хүмүүжүүлэх" талаар 66 хувь нь бэрхшээлтэй тулгарсан гэж үздэг байна. Ялангуяа хот дотор амьдардаг тэжээвэр амьтад 78 хувьд нь бэрхшээл учирдаг байна. Гэрийн тэжээвэр амьтдын эздэд тулгардаг хамгийн нийтлэг бэрхшээлүүд нь амьтан тэжээдэг хүн амын 34 хувь нь ямар нэгэн бэрхшээл байхгүй гэсэн бол амьтан тэжээх зардал ихтэй (23%), ялгадас цэвэрлэх зардалтай (23%), амралтаараа тэжээвэр амьтдаа авч явах чадваргүй (22%), хангалттай анхаарал тавьж чаддаггүй (19%), тогтмол дасгал хийдэггүй (18%), хангалттай унтдаггүй (15%), тэднийг арчлах (14%), гэрт гэмтэл учруулах (13%), боломжийн үнэтэй байр олох (11%), амьтдыг гэрт байлгах (9%), бусад (3%) гэсэн байна.

Гэртээ амьтан тэжээдэг хүн амын хувьд 18-24 насныхан 70 хувь, 40-54 насныхан 66 хувь, 70 ба түүнээс дээш насны 59 хувь нь амьтан тэжээдэг байна. 2016 онд Австрали дахь гэрийн тэжээвэр амьтдын өмчлөлийн тайлан гарснаас хойш хэд хэдэн эрх мэдлийн хүрээнд гэрийн тэжээвэр амьтдын өмчлөлийн зохицуулалт, ялангуяа түрээсийн өмчтэй холбоотой өөрчлөлтүүдийг хийсэн байна. Гэрийн эзэн гэрээ байгуулах шаардлагатай хэвээр байгаа ч гэрийн тэжээвэр амьтдыг зөвшөөрдөггүй гэсэн үндсэн байр сууринаас илүүтэй түрээсийн байранд тохирох гэрийн тэжээвэр амьтдыг зөвшөөрөхгүй байх шалтгааныг шаардах эрхтэй байдаг. Өнгөрсөн жил Викториа мужид хийсэн шинэчлэлийн хүрээнд түрээслэгч бүр гэрийн тэжээвэр амьтан тэжээх эрхтэй болсон. Байрны эзний зөвшөөрөл авах нь хэвээр байгаа хэдий ч шинэ хуулиудад гэрийн тэжээвэр амьтнаас татгалзах нь илүү хэцүү болж, түрээслэгчид сөрөг шийдвэрийг давж заалдах эрх шинээр бий болж байна.

Мэдээллийн эх үүсвэр: [www.animalhealthaustralia.com.au](http://www.animalhealthaustralia.com.au)

## ГЕРМАН УЛС

ХБНГУ-д 2021 онд 10,3 сая нохой, 4.6 сая жижиг амьтад, 3.1 сая гоёлын шувуу, усны амьтан 2.3 сая байна. Герман улсад тэжээвэр амьтанд нохой, муур туулай, гоёлын шувуу, загас, усан гахай, хулгана, яст мэлхий, гүрвэл, аалз зэрэг олон төрлийн амьтан багтдаг байна. Герман улсын судалгааны дүнгээс харахад ганц бие ахмад настан ганцаардлаас гарах, сэтгэл зүйн эмчилгээний нэг хэлбэр нь амьтан тэжээх арга болоод байна. Нийт амьтан тэжээдэг хүн амын 29 хувь нь ганц бие гэсэн байна.

ХБНГУ нь Амьтан тэжээх хууль, Иргэний хууль, Орон сууцны хуулиар зохицуулалт хийгддэг бөгөөд муж тус бүрд дүрэм журамтай. Амьтан тэжээх хуулийн дагуу орон сууцны төрлөөс шалтгаалан нийтийн орон сууцанд амьтан тэжээхийг зөвшөөрдөггүй байна. Нийтийн орон сууцанд бусдад гэм хор учруулахгүй, оршин суугчдын эрх ашгийг зөрчихгүй бол амьтан тэжээхийн тулд оршин суугчдын холбоонд хандах бөгөөд анх байр түрээслэхдээ гэрээндээ энэ талаар тусгуулж, оршин суугчдын зөвшөөрөл авдаг байна. Оршин суугчдын холбоо нь нэг мужид нэг байдаг бөгөөд иргэдэд байр түрээслэх, гэрээ байгуулах ажлыг хариуцдаг байна.

Жижиг амьтад буюу хүнд саад болохгүй, гэмтэл учруулахгүй, орчин бохирдуулахгүй туулай, гоёлын шувуу, гүрвэл, усан гахай, яст мэлхий, засаг зэрэг жижиг амьтдыг тэжээхийг зөвшөөрдөг байна. Түүнчлэн онцгой тохиолдолд буюу өвлөгдөж ирсэн, хөгжлийн бэрхшээлтэй, үл хөдлөх хөрөнгөө мануулах, сэтгэл зүйн эмчилгээний заавраар амьтан тэжээхийг зөвшөөрдөг байна. Зодоонч ноход, чанга дуугаар хуцдаг, орчин бохирдуулдаг, содон чанга дуутай шувуу зэрэг тухайн амьтны төрөл, зан чанар зэргээс шалтгаалан тухайн байранд оршин суухыг зөвшөөрдөггүй байна.

Мэдээллийн эх үүсвэр: <https://theculturetrip.com/europe/germany>

## ӨМНӨД СОЛОНГОС УЛС

БНСУ-д 6.38 сая өрхөд 8.6 сая тэжээвэр амьтан байдаг. Өмнөд Солонгосын гэрийн тэжээвэр амьтдын тухай хууль тогтоомжийг 2013 онд шинэчлэн боловсруулж, тэжээвэр амьтдын хамрах хүрээг Хөдөө аж ахуйн яамнаас тодорхойлсон байна. БНСУ-ын гэрийн тэжээмэл амьтадтай өрхүүдийн 80.7 хувь нь нохойг тэжээвэр амьтнаар, 25.7 хувь нь муурыг илүүд үздэг байна. Өмнөд Солонгост хамтрагч амьтдын тоо, ялангуяа нохой, муурын тоо хурдацтай нэмэгдэж байгаа нь гол төлөв цөм гэр бүл, ганц хүнтэй өрхийн тоо нэмэгдсэнтэй холбоотой юм.

Өмнөд Солонгосын засгийн газар Амьтдыг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн журамд заасны дагуу гурван сартайгаас дээш насны "харгис" гэсэн ангилалд багтсан нохойг хошуувчтай байлгахыг үүрэг болгосон. Эдгээр үүлдрийн нохойг сургуулийн өмнөх боловсрол, өдөр өнжүүлэх төв, бага сургууль, дунд сургууль, ахлах сургуульд авч очихыг хориглоно. Түрэмгий нохой эзэмшигчид нохойгоо хориглосон газар руу нэвтрэхээс урьдчилан сэргийлэхийн тулд боловсролын сургалтад хамрагдах шаардлагатай. Ийм тохиолдлыг бууруулахын тулд тус улсын засгийн газраас 2021 оны 2-р сараас эхлэн түрэмгий нохой тэжээдэг хүмүүс даатгалд хамрагдахыг зөвлөжээ.

БНСУ-г хаягдсан амьтны тоо тогтмол өсөж, 2019 онд 136,000-д хүрсэн. Харин үрчлэгдсэн амьтны тоо ердөө 36,000 байна. 2014 онд улсын хэмжээнд тэжээвэр амьтдын бүртгэлийн систем хэрэгжиж, бүртгэлтэй амьтдын тоо 2019 онд 2.1 сая байсан бол 2020 онд 2.3 сая болж өссөөр байна. БНСУ-ын маргаантай сэдэв бол Босинтанг юм. Босинтанг бол нохойн махаар хийсэн шөл юм. Өмнөд Солонгост нохой нядалж, хэрэглэх нь хууль бус юм.

Мэдээллийн эх үүсвэр: [https://en.wikipedia.org/wiki/Pets\\_in\\_South\\_Korea](https://en.wikipedia.org/wiki/Pets_in_South_Korea)

## ИРЛАНД УЛС

Ирланд улс 2020 оны байдлаар 457,0 мянган нохой, 290,0 мянган мууртай байна. Ирланд улсад Нохойг хянах тухай хууль, Нохойн хяналтын журам, Нохойн бичил чип хийх журам, Мал, амьтны эрүүл мэнд, халамжийн журам, Амьтны паспортын журам, Үржлийн байгууллагуудын тухай зэрэг хууль, журам үйлчилдэг бөгөөд нохойн хяналтын төвүүд нохойн лиценз олгох, бичил чип хийх бүртгэлийн талаарх үндэсний мэдээлэлд үндэслэн тэжээвэр нохойны тоо сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой байсан. Нохойн тухай журамд зарим үүлдрийн нохойг уях, хошуувчтай байлгах зэрэгт хязгаарлалт тавьсан болон өмчлөлийг тодорхойлох тухай заасан байдаг.

Нохойн хяналтын 27 төвөөр дамжуулан нохойн тоог тогтоож, жилийн статистик тоог орон нутгийн засаг захиргаа бүр нэгтгэдэг. Ирланд улсын судалгааны байгууллагаас хийсэн судалгааны дүнгээр нохой тэжээх нь байршил, байшингийн төрөл, өрхийн нийгмийн ангилал, өрхийн байр суурь, тухайн айлд хүүхэд байгаа эсэх, мөн муур байгаа эсэхээс хамаардаг байна.

Ирланд улсын 50 ба түүнээс дээш насны хүн амд хийсэн судалгаагаар 50-64 насны (51%) насанд хүрэгчдийн дунд нохой тэжээх чадвар хамгийн өндөр байна. 75 ба түүнээс дээш насныхан хамгийн бага 25.0 хувь байна. Үүнээс гадна, хөдөөгийн оршин суугчдын 49.0 хувь нохойтой байгаа нь Дублин хот (26%)-ын оршин суугчдаас бараг хоёр дахин их байна. Ирланд улсын орон сууцны түрээсийн гэрээний 2021 оны гарын авлагад гэрийн тэжээвэр амьтад эрүүл мэндэд эрсдэлгүй, аюултай биш бол нэг байранд НЭГ нохой, НЭГ муур тэжээхийг зөвшөөрнө. Гэрийн тэжээвэр амьтад нь танд төвөг учруулахгүй бөгөөд та гэрийн тэжээвэр амьтдаа тэжээхийг хүсэж буй төрөлдөө тохирсон гэр оронтой байх ёстой гэж заасан байна.

Зураг 15. Нохойн ялгадасны сав, Ирланд улс. 2022.10 сар



Мэдээллийн эх үүсвэр: [www.dublin.ie](http://www.dublin.ie)



## **5. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

### **5.1 СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ**

Суурьшлын бүс дэх тэжээвэр амьтантай холбоотой стандарт талаас нь судалсан судалгаанууд нийслэл, дүүргийн хэмжээнд хараахан хийгдээгүй байна. Тиймээс, энэхүү судалгаагаар суурьшлын бүс дэх тэжээвэр амьтантай холбоотой стандартыг судлахыг зорьсон бөгөөд Улаанбаатар хотын 5 дүүргийн орон сууцны хороололд гэрийн тэжээвэр амьтан тэжээдэг болон тэжээдэггүй гэсэн нийт 2161 өрх, 80 сууц өмчлөгчдийн холбоог хамруулан судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Суурь судалгааг 3 дэд хэсэгт хуваан, эхний хэсэгт гэрийн тэжээвэр амьтантай өрхөд зориулсан асуулга, 2 дугаар хэсэгт гэрийн тэжээвэр амьтангүй өрхөд зориулсан асуулга, 3 дугаар хэсэгт нийт өрхийг хамруулсан тэжээвэр амьтны стандартын талаарх мэдлэгийг асууж тодруулсан болно.

Суурь судалгааны үр дүнгээс харахад гэрийн тэжээвэр амьтантай өрхүүдийн дийлэнх нь нохой, муур тэжээдэг бөгөөд хүүхдүүд тэжээхийг хүссэн, хоббигоороо тэжээх болсон шалтгаануудыг хамгийн их дурджээ. Орон сууцны хороололд тэр тусмаа гэрийн тэжээвэр амьтан салхилуулах газар, байрны гадна орчинд байхгүй гэсэн хүндрэл дийлэнх хариултыг эзэлжээ.

Гэрийн тэжээвэр амьтантай өрхийн гишүүд тэжээвэр амьтнаас шалтгаалсан өвчнөөр өвдөж байгаагүй, амьтны гэрчилгээтэй, вакциндаа тогтмол хамрагддаг бөгөөд ялгадсыг нь цэвэрлэдэг, байнга усанд оруулах зэргээр ариун цэврийг тогтмол сахидаг хариултуудыг дийлэнх нь өгсөн байна. Харин спэй буюу үржил хязгаарлах мэс заслыг олонх нь хийлгээгүй гэсэн бөгөөд шаардлагагүй гэж үзсэн байна.

Гэрийн тэжээвэр амьтан тэжээдэггүй өрхийн хувьд гэрийн тэжээвэр амьтантай хөршүүд нь хүндрэл учруулдаггүй гэж 75.0 хувь нь хариулсан. Харин хүндрэл учруулсан (25%) гэж хариулснаас хүндрэлийг хамгийн чухлаар нь эрэмбэлэн авч үзэхэд гэрийн тэжээвэр амьтан нь янз бүрийн чанга дуу гаргаж амрахад саад болдог гэж хариулжээ.

Гэрийн тэжээвэр амьтны стандартын талаарх мэдлэг, хандлагын талаарх хэсгийн асуулгын үр дүнг харвал орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхтэй холбоотой заавал мөрдөх аюулгүй байдлын журам, стандартын талаар 79.1 хувь нь мэддэг гэж хариулсан бөгөөд интернет/вэб хуудаснаас энэхүү мэдээллээ авдаг байна.

Өрхийн судалгаанд оролцогчдын 73.5 хувь, сууц өмчлөгчдийн холбоодын 86.0 хувь нь орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд оршин суугчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор Улаанбаатар хот стандарттай байх шаардлагатай гэж үзсэн байна.

Хотын стандартад орон сууцанд гэрийн тэжээвэр амьтан тэжээхэд нэмэлт төлбөр хураамжтай болох, орон сууцны гадна талд гэрийн тэжээвэр амьтан салхилуулах зориулалтын талбайтай болох, том хэмжээтэй нохой болон гаршуулсан зэрлэг амьтан орон сууцанд тэжээхгүй байх, иргэдийн гэртээ амьтан тэжээх талаар мэдлэгийг дээшлүүлэх, орон сууцанд тэжээж байгаа гэрийн тэжээвэр амьтны эрүүл мэнд, аюулгүй байдал, тав тухыг хангах талаарх заалтуудыг тусгахаар саналаа өгсөн байна.

Судалгааны үр дүнд үндэслэн тэжээвэр амьтантай холбоотой хотын стандартыг батлуулан, энэ талаарх мэдээ, мэдээллийг олон сувгаар тухай бүр түгээж иргэдийн ойлголт мэдлэг өгөх, орон сууцны гадна талд гэрийн тэжээвэр амьтан салхилуулах зориулалтын талбайтай болох асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай байна.

### **5.2 САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

Суурьшлын бүсийн нийтийн орон сууцны орчны эрүүл аюулгүй байдлын стандартыг бий болгосноор амьтан эзэмшигчдийн үүрэг хариуцлага нэмэгдэж, амьтанд энэрэнгүй хандах, амьдрах таатай орчныг бүрдүүлэх, оршин суугчдын эрх ашгийг хүндэтгэн, хүрээлэн буй орчны эрүүл, аюулгүй байдлыг хангадаг.

Иймд орон сууцанд амьтан тэжээх стандартыг тогтоохдоо эзэмшигчийн болон бусад байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн үүрэг хариуцлагыг тодорхой зааж өгөх шаардлагатай.

Мөн гэрийн тэжээвэр амьтныг хоол, ундаар хангах, хөдлөх хангалттай орон зай бүхий орон байраар хангах, зан авирын доголдолтой болгохгүйн үүднээс сургах, мал эмнэлгийн нэгжид тогтмол үзүүлэх, вакцинд хамруулах, олон нийтийн газарт ялгадсыг цэвэрлэх, хараа хяналтгүй төөрч тэнүүчлэхээс урьдчилан сэргийлэх, үржлийг хязгаарлах, бичил чип суулгуулах, иргэд оршин суугчдын амгалан тайван, ая тухтай байдлыг алдагдуулахгүй байх зэрэг арга хэмжээг стандартад тусгах шаардлагатай.

Орон сууцны орчныг гол бохирдуулагч нь нохой бөгөөд нохой эзэмшигч иргэд нохойны эрүүл мэндийг хамгаалах, элдэв муу занд сургахгүй байх, гадуур авч гарахдаа уяа, хошуувч хийх, ялгадсыг цэвэрлэж сурах хэрэгтэй. Түүнчлэн нохойн эрүүл мэндээс шалтгаалан тухайн өрхийн бүх гишүүдэд нөлөөлдөг. Нохой тэжээгч нь нохойны эрүүл мэнд, өвчлөл, асаргаа, маллагааны талаар тодорхой мэдлэгтэй байх хэрэгтэй. Гэрийн тэжээвэр амьтад өрхийн гишүүдийн эрүүл мэндэд тустай. Сүүлийн жилүүдэд гэртээ амьтан тэжээснээр цусны даралт, холестерин, триглицеридын түвшин, ганцаардлын мэдрэмжийг бууруулахад тусалдаг гэж үздэг байна. Гэрийн тэжээвэр амьтантай байх нь олон давуу талтай ч хүмүүсийг өвчлүүлдэг эмгэг төрүүлэгчдийг дамжуулдаг тул эрүүл ахуйн нөхцөлийг сайтар хангах шаардлагатай. Өвчилсэн нохойн зан ааш хувирах, ядрах, хүрэх үед хуцах зэрэг шинж тэмдэг үзүүлдэг. Мөн буруу хоолны дэглэм, дасгал хөдөлгөөн хангалтгүй үед нохой илүүдэл жинтэй болдог байна. Нохойны хэвтрийг байнга цэвэрлэх, долоо хоног бүр нохойгоо угаах, гадуур гарсны дараа сарвууг угаах зэрэг дадлыг хэвшүүлснээр нохойг харшлаас хамгаалах, улмаар өрхийн гишүүдийг өвчлөлөөс хамгаална. Нохойн арьсны өвчин эзэндээ маш их хор хөнөөлтэй. Зарим тохиолдолд нохойн арьсны өвчин хүрээлэн буй орчноос дамждаг. Нохой эзэмшигч нь нохойныхоо зан авирыг анхааралтай ажиглаж, хүрээлэн буй орчин, хооллолт, бие махбодод нь гарч буй өөрчлөлтийг байнга анхаарч, өөрчлөгдсөн тухай бүрд эмнэлэгт үзүүлэх шаардлагатай. Нохой эзэмшигч нь нохойгоо салхилуулахдаа биеийн бэхлэгээтэй, эвхэгддэг оосор, эмчилгээний уут буюу амттан, ялгадасны уут, тоглоомыг заавал авч явах хэрэгтэй. Эдгээр эд хэрэгсэл нь нохойтойгоо харилцах, итгэлцэх, аюулгүй удирдах боломжийг олгодог байна.

Бүх тэжээвэр амьтад бүх хүмүүст тохирохгүй. Гэрийн тэжээвэр амьтдын хэрэгцээг харгалзан үзэхээс гадна хэн түүнтэй хамт амьдрахыг анхаарч үзэх хэрэгтэй. Зарим тэжээвэр амьтад, тухайлбал **мөлхөгчид, хоёр нутагтан**, болон **мэрэгч амьтад**, 5-аас доош насны хүүхэд, 65-аас дээш насны насанд хүрэгчид, дархлаа султай хүмүүст өвчлөх магадлал өндөр байдаг тул гэртээ тэжээхийг зөвлөдөггүй.

Гэрийн тэжээвэр амьтадаа эрүүл байлгах нь гэр бүлийн гишүүд болон хөршүүдийн эрүүл мэндэд тустай. Гэрийн тэжээвэр амьтдыг эрүүл хооллолт, цэвэр ус, хоргодох байр, дасгал хөдөлгөөн хийх боломжтой эсэхийг шалгаарай. Нохой, муур, шишүүхэй, гарам, игуана бүр насан туршдаа малын эмчийн эмчилгээ хийлгэх ёстой. Ерөнхийдөө нохой өдөрт дор хаяж нэг эсвэл хоёр цаг дасгал хийх шаардлагатай байдаг. Гэсэн хэдий ч энэ нь таны тэжээвэр амьтдын хэмжээ, үүлдэр, наснаас хамаарч өөрчлөгдөж болно.

Гар угаах нь амьтдын дэргэд эрүүл байх хамгийн үр дүнтэй аргуудын нэг бөгөөд таныг бусад өвчнөөс урьдчилан сэргийлэхэд тусалдаг. Гэрийн тэжээвэр амьтантай тоглож, хооллож, ялгадсыг нь цэвэрлэсний дараа гараа үргэлж угаах хэрэгтэй.

Гэрийн тэжээвэр амьтдын хоол, тоглоомтой харьцах, тор цэвэрлэх, тэр байтугай гэрийн тэжээвэр амьтадаа үнсэх нь нян дамжуулдаг. Хэдийгээр тэд цэвэрхэн, эрүүл харагддаг ч гэрийн тэжээвэр амьтад нян дамжуулж болно.

Гэрийн тэжээвэр амьтадаа хоол хүнс, ундаа бэлтгэх, үйлчлэх, хэрэглэх, хадгалах газраас хол байлга.

Шимэгч болон бусад эмгэг төрүүлэгчдийг халдварлахаас сэргийлэхийн тулд та хашаанаасаа болон нийтийн эзэмшлийн газраас нохойны ялгадсыг байнга зайлуулах хэрэгтэй.

Гэрийн тэжээвэр амьтдын дэргэд, ялангуяа гэр бүлийн гишүүн бол бяцхан хүүхдүүдийг үргэлж хянаж байх хэрэгтэй. Хүүхэд, ялангуяа 5-аас доош насны хүүхдүүд, гэрийн тэжээвэр амьтантай холбоотой өвчинд илүү өртөмтгий байдаг Учир нь тэд байнга амандаа юм хийж, бохирдсон байж болзошгүй гадаргууд хүрч, гараа угаах нь бага байдаг. Хүүхдүүд гэрийн тэжээвэр амьтдаас халдварладаг зарим өвчний улмаас хүндээр өвчилдөг.

Нийгэмшүүлэх нь тэжээвэр амьтдын аз жаргал, сайн сайхан байдалд зайлшгүй шаардлагатай. Олон тооны амьтад бүлгээрээ амьдрахад зохицсон байдаг. Бусадтай уулзаж, харилцах нь таны гэрийн тэжээмэл амьтны өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж, айдас, түгшүүртэй зан үйлийг багасгаж, арилгах болно.

Гэрийн тэжээвэр амьтдын эрүүл дадал нь гэрийн тэжээвэр амьтдаа үнэлж, эрүүл мэндээ хадгалахад тусална.

- Гэрийн тэжээвэр амьтдаа дээд зэргийн чанартай тэжээллэг хоолоор ханга.
- Өдөр бүр, дор хаяж хагас цагийн турш та тэднийг салхинд гаргах хэрэгтэй.
- Тэдэнд шаардлагатай дархлаажуулалтыг цаг тухайд нь хий.
- Тэдэнд үргэлж толбогүй, ариун цэврийн байгууламжийг байлга.
- Гэрийн тэжээвэр амьтдаа долоо хоногт нэг удаа эсвэл сард нэг удаа малын эмчид үзүүлээрэй.
- Тэдэнтэй харилцаж, удаан хугацаагаар ганцаараар нь үлдээхээс зайлсхийх.

Оросын Холбооны улс нь нийтийн орон сууцанд амьтан тэжээхийг зөвшөөрдөг бөгөөд гэртээ амьтан тэжээдэг иргэдийн үүрэг хариуцлагыг тодорхой зааж өгсөн байна. Иймд бид ОХУ-ын хууль, стандартыг нарийвчлан судлан өөрийн орны нөхцөлд тохируулан нутагшуулах нь зүйтэй гэж бодож байна. Орон сууцанд байлгах онцлог шинж чанарууд нь амьтны төрлөөр тодорхойлогддог, учир нь тэдгээр нь тус бүр өөрийн гэсэн онцлогтой бөгөөд арчилгааны тодорхой дүрмийг дагаж мөрдөхийг шаарддаг. Нэг чухал зүйл бол хүмүүсийн амьдрах орон зайг зориулалтын дагуу ашиглаж байгаа байдал бөгөөд дотор нь амьтан байгаа нь бусад хүмүүсийн амьдралын чанарыг дордуулахгүй байх явдал юм. ОХУ-ын тэжээвэр амьтдын хууль, стандартад доорх зүйлсийг тусгасан байна.

Гэрийн тэжээвэр амьтан эзэмшигч нь гэрийн тэжээвэр амьтанд анхаарал халамж тавьж, түүнд сайн хандах үүрэгтэй. Зарим тохиолдлоос бусад тохиолдолд та амьтныг ашиг тус (бизнесийн үйл ажиллагаанд) ашиглах боломжгүй. Гэрийн тэжээвэр амьтдыг гэмтээх, өвтгөхийг хориглоно. Муур, нохой эсвэл бусад тэжээвэр амьтдыг зөвхөн эзэмшигчийн амьдардаг байранд байлгахыг зөвшөөрдөг. Хуулийн дагуу орон сууцны гаднах талбай, тухайлбал, үүдний танхим, коридор, буух гэх мэтийг амьтан тэжээх зориулалтаар ашиглах боломжгүй.

